11	78	МОНГОЛ УЛСЫН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ ЗАРИМ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2022-11-11 Дугаар 2022 №72	1.2. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажил, зураг төсөв болон техник, эдийн засгийн үндэслэл боловсруулах ажлыг 2023 онд шуурхай зохион байгуулах;	2023 оны Төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний барилга байгууламж байхгүй болно. ЦХХХСайдын багцын 2024 оны төсвийн төсөл боловсруулахдаа "Шинэ сэргэлтийн бодлого", 2020 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т туссан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд чиглэсэн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний бэлтгэл ажлыг төлөвлөн ажиллаж байна.	70%	Үгүй	
	79		1.3. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийнх нь эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах;	ЦХХХСайдын багцын 2024 оны төсвийн төсөл боловсруулахдаа Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилго тавьж анхаарч ажиллаж байна.	100%	Үгүй	
	80		1.7. Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн нэгдсэн цахим бүртгэл, мэдээллийн системийг бий болгох, ашигт мөлтөм олборлох, боловсруулах, тээвэрлэх зэрэг бүх үе шатанд хамаарах гэрээг татварын нэгдсэн системд бүртгүүлж, экспортод гаргах, нууцын зэрэглэлд хамаарах худалдах, худалдан авах гэрээг Улсын Их Хуралд танилцуулах;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.
12	81	ХУУЛЬ БАТАЛСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-12 Дугаар 2023 №06	1.1. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх хүртэлх хугацаанд экспортод гаргах нүүрсийг "Монголын хөрөнгийн бирж" ТӨХК-ийн цахим системээр дамжуулан арилжаалах нөхцөлийг бүрдүүлэх, экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжаатай холбогдсон харилцааг зохицуулсан журмыг баталж, мөрдүүлэх;	Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас ирүүлсэн тогтоолын төсөл, "Экспортод гаргах нүүрсний нээлттэй цахим арилжааны журам"-ын төсөлд санал боловсруулж 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдрийн 01/2194 дугаар албан бичгээр харууг ирүүлсэн.	100%	Үгүй	
	82		1.3. уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн систем, программ хангамжийг биржийн үйл ажиллагаанд ашиглах боломжтой эсэхийг судалж, холбогдох арга хэмжээ авах.	Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагааг цахимжуулж, үндэсний мэдээллийн технологийн компаниудын хөгжүүлсэн системийг ашиглах талаар Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу зөвлөмж, дүгнэлт гаргуулах хүсэлт ирүүлээгүй тул хэрэгжилтийг тооцох хугацаа болоогүй байна.	Х.Б	Үгүй	
	83	ОРХОНЫ ХЭНДИЙД "ШИНЭ ХАРХОРУМ" ХОТ БАЙГУУЛАХ	2.2. "Шинэ Хархорум" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө, зам, тээвэр, эрчим хүч, инженерийн дэд бүтцийн хангамжийн техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг боловсруулах;	Шинэ хотын холбоо мэдээллийн эх үүсвэр, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх саналыг боловсруулахаар төлөвлөж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас	30%	Үгүй	

13	84	ТУХАЙ 2023-01-12 Дугаар 2023 №07	2.3. "Шинэ Хархорум" хотыг байгуулах ажлыг удирдан зохион байгуулах байнгын бүтэц, тогтолцоог бий болгох, бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлах, түүнд шаардагдах хөрөнгийг угс, орон нутгийн төсвийн болон санхүүжилтийн бусад эх үүсвэрээс төсөвлөн үе шаттайгаар хэрэгжүүлэх.	Шинэ хотын холбоо мэдээллийн эх үүсвэр, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх саналыг боловсруулахаар төлөвлөж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас	30%	Үгүй	
14	85	НҮҮРСНИЙ ТЭЭВЭРЛЭЛТ, ЭКСПОРТТОЙ ХОЛБООТОЙ АСУУДЛААРХ ЕРӨНХИЙ ХЯНАЛТЫН СОНСГОЛЫН ТАЙЛАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ 2023-01-19 Дугаар 2023 №08	3/б. нүүрсний тээвэрлэлт, экспортой холбоотой оффтейк гэрээнүүд, түүнийг нууцад хамааруулсан шийдвэр, ажил гүйцэтгэх, туслан гүйцэтгэх гэрээнүүд, 2010 оноос хойших 1072 хувьцаа эзэмшигчдийн нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл, гүйцэтгэх удирдлагын хурлын бүх тэмдэглэл, тушаал, шийдвэр, худалдах, худалдан авах гэрээнүүдийн хуулбарыг хуульд заасан үндэслэл, журмын дагуу олон нийгэд ил тод болгох;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу мэдээлэл хариуцагч этгээд буюу Улсын Их Хурлын тогтоолд дурдсан мэдээллийг хадгалж, хамгаалж буй этгээд нийгэд ил тод болгох үүрэг хүлээнэ.	Х.Б	Тийм	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна
	86		3/в. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн зөвлөмжид үндэслэн аж ахуйн болон хөрөнгө оруулалтын чиглэлийн аливаа оффтейк гэрээ байгуулахгүй байх, улсын нууцад хамааруулахгүй байх, шаардлагатай тохиолдолд Улсын Их Хуралд танилцуулж, хэлэлцүүлэх;	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна. Улсын Их Хурлын тогтоолд дурдсан гэрээг Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам хариуцан байгуулна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна
УИХ-ын байнгын хорооны тогтоол							
15	87		1.1/. Төрийн үйлчилгээний цахим шилжилттэй холбоотойгоор урьд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, тэдгээрийн уялдаа холбоонд үнэлэлт, дүгнэлт хийж, нэгдсэн удирдлага, төлөвлөлтөөр хангах бүтцийг тодорхойлж танилцуулах;	Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг баталж, тус хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7, 32.1.8, 32.1.9 дэх хэсэгт тус тус заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн үйлчилгээний цахим шилжилттэй холбоотойгоор урьд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилт, тэдгээрийн уялдаа холбоонд үнэлэлт, дүгнэлт хийж, нэгдсэн удирдлага, төлөвлөлтөөр хангахаар заасан болно. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 05 дугаар сарын 02-ний өдрийн А/18 дугаар тушаалаар "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг боловсруулан батлуулсан. https://legalinfo.mn/mn/detail?lawId=16468669176031	100%	Үгүй	
	88		1.2/. Төрийн байгууллагуудын мэдээллийн систем, өгөгдөл хамгаалалтад мэдээллийн аюулгүй байдлын аудит хийлгэж, нэгдсэн дүнг танилцуулах;	"Монгол Улсын Засгийн газраас "Цахим Монгол" зорилтын хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний явц, үр дүн" сэдэвт аудитыг Аудитын ерөнхий газартай хамтран 2023 оны 3-4 дүгээр улиралд хийхээр төлөвлөсөн ба одоогоор аудитын урьдчилсан судалгааны ажлын уулзалтууд зохион байгуулж ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих	30%	Үгүй	
	89		1.3/. Төрийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах суурь үзэл баримтлалыг хувийн хэвшил, иргэний байгууллагын оролцоотойгоор боловсруулж батлах, түүнд үндэслэн цахим шилжилтийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг баталж шаардагдах төсвийг 2020-2022 оны улсын төсөвт тусгаж хэрэгжүүлэх;	Төрийн байгууллагуудын мэдээллийн системийн уялдаа холбоо, нэгдмэл байдлыг хангах хүрээнд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө нийтийн мэдээллийн систем хоорондын харилцан уялдаа, нийтийн мэдээллийн системийн эдийн засгийн үр ашгитай байдал, хэрэглэх технологийн нийцэл, хүний хэрэглээнд тохирсон байдал, хэрэглэх аргуудаар зохицуулсан. "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргах журам"-ыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/18 дугаар тушаалаар баталсан. Тус журмын дагуу Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө тухайн үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлтийг боловсруулах байнгын ажиллагаатай ажлын хэсгийг сайдын 2022 оны 05 дугаар сарын 20-ны А/25 дугаар тушаалаар байгуулсан. Дээрх ажлын хүрээнд бүх яамдууд руу тухайн салбарын хүрээнд хийгдэх нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй холбоотой төслүүдийн мэдээллийг ирүүлэх талаар 03/1008 тоот бүхий бичгийг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдөр хүргүүлэн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%	Тийм	цахим шилжилтийг хэрэгжүүлэх стратеги төлөвлөгөөг баталж шаардагдах төсвийг 2024 оны төсөвт санал илгээх боломжтой бөгөөд 2020-2022 онд шаардагдах төсвийг батлаагүй байна.
	90	Чиглэл өгөх тухай 2019-06-05 Дугаар 2019 №05 "Цахим бодлогын түр хороо"	1.10/. Үндэсний эв нэгдэл, язгуур ашиг сонирхолд харшлах цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний сөрөг мэдээллээс иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний зөв зохистой хэрэглээг сурталчлах, сөрөг нөлөөлөөс урьдчилан сэргийлэх, бүх нийтийн тоон бичиг үсгийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх тодорхой төсөл, арга хэмжээг төлөвлөн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2020-2022 онуудад хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгах, хэрэгжилтийг эрчимжүүлэх;	"Цахим орчин, цахим орчин дахь нийгмийн сүлжээний сөрөг мэдээллээс иргэдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал ""Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хууль""-ийг боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Улсын их хуралд өргөн мэдүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр 6 бүлэг 12 зүйлтэйгээр Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийг баталсан. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэд "Цахим орчин дахь хүүхэд хамгаалал" чиглэлээр байнгын ажиллагаат ажлын хэсэг байгуулан ажиллуулахаар сайдын 2022 оны А/19 дугаар тушаал батлагдсан. Инновац, цахим бодлогын байнгын хороо, Монголын сурагчдын холбооноос зохион байгуулсан "Follow and unfollow" үндэсний аян зохион байгуулах ажлын хэсэгт ажилласан. Unsent аяныг хэрэгжүүлсэн. Бүх нийтийн цахим үр чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах зорилгоор Сингапур, Казахстан, Филиппин улсуудын жишээг судлан бүх нийтийн цахим үр чадварыг дээшлүүлэх хөтөлбөр боловсруулах зорилгоор олон улсад хэрэглэгддэг цахим үр чадварын бүтцийн хүрээний судалгаа хийсэн. ""Цахим үр чадвар, боловсролыг дэмжих"" хөтөлбөр болон үйл ажиллагааны төлөвлөгөөний төслийг боловсруулсан.	100%	Үгүй	

91	1.11/. Цахим орчин дахь хууль бус контентын хандалтыг хязгаарлах, худал мэдээ, хуурамч хэрэглэгчийн бүртгэлийг устгах, хариуцлага тооцох тогтолцоог бий болгох, холбогдох байгууллагын чиг үүрэг, оролцоог оновчтой зохион байгуулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх журмыг боловсруулах, батлах, хэрэгжилтэд нь хяналт тавих, цахим орчны сөрөг үр дагавраас сэргийлэх, зохистой хэрэглээг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;	2022 оны байдлаар Төрийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах, цахим орчин дахь хууль бус мэдээллийн талаар шуурхай мэдээлэл солилцох зорилгоор doc.crc.gov.mn системийг ашиглаж байна. Тус системээр эрх бүхий байгууллагаас 301 албан бичгээр цахим орчин дахь хууль бус контентын хандалтыг хязгаарлах, худал мэдээлэл, хуурамч хэрэглэгчийн бүртгэлийн устгуулах 1373 контент устгуулах хүсэлт ирүүлснийг Мета командид хүргүүлж, 368 /26.8%/ контентийг устгуулсан.	100%	Үгүй	
92	1.13/. Цахим орчин дахь хүүхдэд сөрөг нөлөөтэй контентыг тодорхойлох эрх бүхий төрийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулж, гомдлыг шуурхай шийдвэрлэх системийг бий болгох;	Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлуулсан. Уг хуульд хүүхдийн бие мэхбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан, хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан, хүүхдийг гуйлга гуйх, тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, үеэсн, өдөөн хатгасан, сурталчилсан контентыг олон нийтийн сүлжээнд нийлэхгүй, түгээхгүй байхаар, энэ төрлийн контентыг нийтэлсэн, түгээсэн тохиолдолд олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч байгууллагад хандаж контентыг хязгаарлах, мөн урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлуудыг цогц байдлаар зохион байгуулахаар тусгасан. Мөн хүн, хуулийн этгээдээс эерчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэх механизмыг бүрдүүлж, Кибер халдлага, эерчилтэй тэмцэх нийтийн төвийн олон нийттэй харилцах нэгж нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн агуулга, нөхцөлийг харгалзан хүсэлтийг 72 цагийн дотор хянан шийдвэрлэхээр тусгасан.	100%	Үгүй	
93	1.14/. Цахим орчин дахь нийгмийн сүлжээнд хэрэглэгч утасны дугаараар бүртгүүлэхтэй холбогдох хууль тогтоомжийн төслийг санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;	Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлуулсан. Уг хуульд хүүхдийн бие мэхбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан, хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан, хүүхдийг гуйлга гуйх, тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, үеэсн, өдөөн хатгасан, сурталчилсан контентыг олон нийтийн сүлжээнд нийлэхгүй, түгээхгүй байхаар, энэ төрлийн контентыг нийтэлсэн, түгээсэн тохиолдолд олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч байгууллагад хандаж контентыг хязгаарлах, мөн урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлуудыг цогц байдлаар зохион байгуулахаар тусгасан. Хуулийн 7.1.5-д олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч нь хэрэглэгчийг харилцах утасны дугаар, эсвэл цахим шуудангийн хаягаар баталгаажуулан бүртгэхээр тусгасан.	100%	Үгүй	
94	1.15/. Хилийн чанадад амьдарч буй Монголчууддаа төрийн үйлчилгээг ойртуулах, цахимжуулах;	Төрийн үйлчилгээг Монгол Улсын иргэд оршин суугаа газраас үл хамааран түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэх зорилгоор Төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэг (төрийн үйлчилгээний операторын систем)-ийг нийт 8 газарт буюу БНСУ-ын Сөүл хот дахь консулын байр, Хөдөлмөр нийгмийн хамгааллын газар, Бусан хот дахь консулын газар, Австри улсын Вена хотын элчин сайдын яам, Энэтхэг улсын Ерөнхий консулын газар, Сингапур улсын Консулын газар, Япон Улсын Токио хот дахь элчин сайдын яам, Осака хот дахь Ерөнхий консулын газарт тус тус нээсэн. Хавсралт : 1 файл	100%	Үгүй	
95	Нэг.1/. иргэн, хуулийн этгээдийн мэдээллийн систем, сүлжээнд чиглэсэн кибер халдлага, эерчлийг илрүүлэх, таслан зогсоох, хариу арга хэмжээ авах, кибер халдлага, эерчилд өртсөн мэдээллийн системийг нөхөн сэргээхэд дэмжлэг үзүүлэх чиг үүрэг бүхий кибер халдлага, эерчилтэй тэмцэх "Нийтийн төв"-ийг байгуулахад шаардагдах санхүүжилтийг шийдвэрлэх; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (П.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)	"1. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 493 дугаар тогтоолоор "Кибер аюулгүй байдлын үндэсний стратеги"-ийг, 2023 оны 42 дугаар тогтоолоор "Кибер аюулгүй байдлын зөвлөлийн дүрэм"-ийг тус тус батлуулсан. 2. "Кибер халдлага, эерчилтэй тэмцэх нийтийн төв" улсын төсөвт үйлдвэрийн газрыг байгуулах, түүний дүрмийг батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж байна; 3. "Кибер халдлага, эерчилтэй тэмцэх нийтийн төв" программ хангамж, тоног төхөөрөмж бүхий дэд бүтцийг бий болгоход 7,5 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шаардлагатай бөгөөд уг зардлыг Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциаттай байгуулсан "Ухаалаг засаг-2" төслийн жагсаалтад оруулж, 2023-2024 онд хэрэгжүүлэхээр ажиллаж байна. 4. Нийтийн төвийн урсгал зардал /6,2 тэрбум төгрөг/-ийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2024 оны төсөвт тусгахаар ажиллаж байна.	70%	Үгүй	

96	<p>Нэг.2/. 2/мэдээллийн технологи, харилцаа холбооны салбарын хүний нөөцийн хөгжил, тогтвортой хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хомсдолоос сэргийлэх зорилгоор дунд хугацааны стратеги боловсруулж хэрэгжүүлэх; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>1. Төрийн албаны тухай хуульд ""Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд мэдээлэл технологийн чиглэлээр нарийн мэргэшсэн, өндөр ур чадвартай хүнийг тухайн чиглэлээр төрийн албанд ажиллуулах шаардлагатай бол албан тушаалын цалингийн итгэлцүүр, шатлалыг Засгийн газар тогтооно"" гэж заасны дагуу тус яам Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран ""Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дээд хязгаар тогтоох тухай"" Засгийн газрын тогтоолын төсөл, холбогдох бусад материалыг боловсруулан Засгийн газрын 2023 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн ээлжит хуралдаанаар хэлэлцүүлж батлуулсан.</p> <p>2. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлэх ""Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр""-ийн хүрээнд богино хугацааны сургалтаар бэлтгэх боломжтой мэдээллийн технологийн 15 чиглэлийн 23 мэргэжлийн жагсаалтыг гаргаж, 2023 оны 03 дугаар 22-ны өдрийн 03/618 дугаар албан бичгээр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд хүргүүлсэн.</p> <p>3. Боловсрол, шинжлэх ухааны яамтай хамтран Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 115 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар ""Дээд боловсролын тэргүүлэх мэргэжлийн чиглэл""-ийн жагсаалтад мэдээллийн технологийн 11, хоёрдугаар хавсралтаар батлагдсан ""Дээд боловсролын эрэлттэй мэргэжлийн чиглэл""-ийн жагсаалтад 3 мэргэжил тус тус орж батлагдсан.</p> <p>Хавсралт : 2 файл</p>	100%	Үгүй	
97	<p>Нэг.3/. олон улсад ашигладаг цахим төлбөрийн системийг Монгол Улсад ашиглах боломжийг бүрдүүлэх; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>Засгийн газрын 2022 оны 371 дүгээр тогтоолоор байгуулагдсан Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2023 оны 03 сарын 02-ны өдрийн 2023/01 тогтоолын 2 дахь заалтаар ""Жуулчдын аюулгүй байдал, санхүүгийн чөлөөт байдлыг хангахын тулд олон улсын төлбөр, тооцооны хэрэгслүүдийг нэвтрүүлэх"" талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг даалгасны дагуу Монголбанкны төлөөлөлтэй хамтарсан уулзалт зохион байгуулж, олон улсын төлбөр, тооцооны хэрэгслүүдийг нэвтрүүлэх боломжийн талаар уулзалт зохион байгуулсан. Олон улсын цахим төлбөрийн хэрэгсэл /PayPal, Stripe, Мир, WechatPay, БНСУ-ын БиСи карт, Олон улсын VISA /-ийг нэвтрүүлэх боломжтой эсэх талаар судалж Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хороонд танилцуулсан.</p>	70%	Үгүй	
98	<p>Нэг.4/. нийтийн мэдээллийн систем үүсгэх, хөгжүүлэхтэй холбоотой төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд мэдээллийн технологийн салбарт үйл ажиллагаа эрхэлж байгаа үндэсний аж ахуйн нэгжийг дэмжих, бараа, ажил, үйлчилгээний ашиглалт, хөгжүүлэлтийг нийлүүлэгч аж ахуй нэгж тодорхой хугацаанд хариуцах эрх зүйн орчныг боловсронгуй болгох; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>Төрийн байгууллага мэдээллийн технологийн худалдан авалт хийхдээ нэн тэргүүнд дотоодын компаниудын бүтээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, үндэсний дэд бүтцэд суурилсан худалдан авалтын систем бий болгох, түүнд байрших программ хангамжийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагын талаар санал боловсруулж ""Программ хангамжийн их дэлгүүр www.mindgolia.mn"" цахим хуудсыг хөгжүүлэн, ашиглалтад оруулсанаар тус цахим системд 2023 оны 06 дугаар сарын байдлаар 29 ангилалд 378 хуулийн этгээдийн 385 бүтээгдэхүүн байршаад байна. www.mindgolia.mn</p>	100%	Үгүй	
99	<p>Нэг.5/. нэмэгдсэн өртгийн албан татвар (И-баримт)-ын төлбөрийн цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим төлбөрийн системтэй холбох; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>Нэмэгдсэн өртгийн албан татвар (И-баримт)-ын төлбөрийн цаасан баримтыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим төлбөрийн системтэй холбох ажлын хүрээнд нийт 20 байгууллагыг "e-barimt" системтэй холбосон ба 2023 оны эхний хагас жилийн байдлаар нийт 37,927,857 баримтыг утасны дугаараар бүртгэсэн. Мөн энэ оны 2 дугаар улиралд багтаан "CU" үйлчилгээний төвийг тус системтэй холбохоор, 106 байгууллагын 61,128 хэрэглэгчийн кассын системийг шинэчилж 3.0 хувилбарыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.</p>	100%	Үгүй	
100	<p>Нэг.6/. үндэсний нийтийн түлхүүрийн дэд бүтцийг сайжруулан олон улсын итгэмжлэгдсэн жагсаалтад оруулах; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>2023 оны төсөвт тусгуулахаар Сангийн яам болон Монгол Улсын Их хуралд 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдрийн 01/1366 албан бичгээр хүргүүлсэн боловч Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуульд тусгагдаагүй. Иймээс Монгол Улсын суурь гэрчилгээжүүлэх байгууллагын өнөөгийн нөхцөл байдалд тулгуурлан Нийтийн түлхүүрийн дэд бүтцийн үндэсний суурь гэрчилгээжүүлэх системийг шинэчлэхэд шаардлагатай техник, тоног төхөөрөмжийн нөхцөл, шаардлагыг боловсруулж, хөрөнгө оруулалтын тооцооллыг гаргаж, Дэлхийн банкны олон улсын хөгжлийн ассоциацийтай байгуулсан ""Ухаалаг засаг-2 төсөл""-ийн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад ""Нийтийн түлхүүрийн дэд бүтцийг шинэчлэх"" төсөл хэрэгжүүлэх санал гарган ажиллаж байна.</p> <p>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс</p>	30%	Үгүй	

101	<p>Чиглэл өгөх тухай 2022-10-24 Дугаар 2022 №01 ИЦБХБ</p>	<p>Нэг.7/. ерөнхий боловсролын сургалтад тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх талаар агуулгыг тусгах, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв болон их, дээд сургуулиудад мэдээллийн технологи, программ хангамж, мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн сүлжээ, хиймэл оюун ухаан, өгөгдлийн шинжлэх ухаан зэрэг мэргэжлийн сургалтын хөтөлбөрийг өргөжүүлэх; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>1.Ерөнхий боловсролын сургуульд ахлах ангийн сонгон судлах хичээлийг хэрэгцээ сонирхолд нь үндэслэн танхимгаар судлах боломж бүрдээгүй сурагчдад цахимаар зохион байгуулах боломжийг бүрдүүлж, 2022 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр Монголын анхны цахим сургууль "Medle.mn" орон даяар нээлтээ хийсэн. / 10,407 суралцагч хамрагдсан/ 2. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн А/310 тоот тушаалаар байгуулсан "Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээ" боловсруулах ажлын хэсэг байгуулагдан "Бүх нийтийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн чадамжийн бүтцийн хүрээ"-ний төслийг боловсруулсан. Төслийг танилцуулах, санал солилцох уулзалт, хэлэлцүүлгийг 2023 оны 05 дугаар сарын 09-ний өдөр салбарын хувийн хэвшлийн 30 гаруй төлөөлүүдийг оролцуулан зохион байгуулсан. Мөн дээрх төсөлд иргэд олон нийтээс санал авах мэдээллийг 2023 оны 05 дугаар сарын 05-ны өдөр байгууллагын цахим хуудас болон нийгмийн мэдээллийн сүлжээнд нээлттэй байршуулсан ба хэлэлцүүлэгт оролцогчид болон бусад байгууллагаас нийт 23 санал ирсэн бөгөөд санал тус бүрийг судлан танилцаж, товъёг үйлдэн тусгасан.3. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны "Монгол Улсад шаардлагатай тэргүүлэх чиглэлийн мэргэжлийн жагсаалт" 70 дугаар тогтоолд "Утасгүй холбоо","Өгөгдлийн ухаан","Системийн аюулгүй байдал", "Хиймэл оюун ухаан" зэрэг мэргэжлийг нэмж баталсан. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/160 дугаар тушаалаар Мэдээлэл, харилцаа холбооны технологийн хиймэл оюун ухаан, өгөгдлийн ухаан, мэдээллийн аюулгүй байдал, IoT зэрэг 13 индекс гаргасан. 4. Бүгд Найрамдах Энэтхэг Улсын санхүүжилтээр хэрэгжих буй Мэдээллийн технологи, ауторсингийн төсөлд Мэдээлэл, харилцаа холбооны технологийн инженер, оюутан залуус, багш нарын чадавхыг бэхжүүлэх хөтөлбөрт 401 багш, суралцагчид хамрагдсан. /Linux Training, DATA Visualization, AI & ML, DATA Analytics, VMware, iOS, Java, Soft Skills, Soft Test, BPO, Cyber Security/</p> <p>Хавсралт : 3 файл</p>	100%	Үгүй	
102	<p>Нэг.8/. радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээг тоон технологид шилжүүлэх, шаардлагатай судалгааг хийх, ач холбогдлыг тайлбарлан таниулах, санхүүжилтийг шийдвэрлэх; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>1. Хонхорын аналог радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцыг тоон технологид шилжүүлэх" техник, эдийн засгийн үндэслэлийг шинэчлэн боловсруулж, тус төслийг Бүгд Найрамдах Солонгос Улсын Шинжлэх Ухаан, Харилцаа холбоо, Мэдээллийн технологийн сайдтай 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдөр хийсэн уулзалтаар танилцуулсан. 2. Монгол Улсын хэмжээнд Радио телевизийн үндэсний сүлжээ УТУГ-ын хариуцагч 6 сайт байдаг ба эдгээр сайтаас тоон технологид шилжих боломжтой Хөвсгөл, Говь-Алтай, Баян-Өлгий, Дорнод аймагт байрлах 4 сайтад их хүчний радио өргөн нэвтрүүлгийн хамрах хүрээ болон дохионы чанарын үнэлгээг 3 дугаар улиралд багтаан хийхээр ажиллаж байна (2023 оны 3 дугаар сард Хөвсгөл аймгийн сайтад хийсэн) 3. Улаанбаатар хотын FM радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах станцыг тоон технологид шилжүүлэх "Хэт богино долгионы DAB+ тоон радио өргөн нэвтрүүлгийн дамжуулах сүлжээ байгуулах" ТЗҮ-г Радио, телевизийн үндэсний сүлжээ УТУГ-тай хамтран 2023 оны 05 сарын 03-ний өдрөөс 06 сарын 28-ний өдрүүдийн хооронд шинэчлэн боловсруулсан.</p>	70%	Үгүй		
103	<p>Нэг.9/. нийгмийн мэдээллийн сүлжээ, цахим хуудас, өргөн нэвтрүүлгийн радио, телевизээр дамжуулан бүх нийтийн тоон бичиг үсгийн чадавхыг дээшлүүлэх, соёлтой хэрэглээг төлөвшүүлэх талаар ойлголт мэдлэг, мэдээлэл өгөх арга хэмжээг зохион байгуулах; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>"1. "И-Монгол академи" УТУГ-ын Цахим ур чадварын газар 2023 оны эхний хагас жилийн байдлаар бүх нийтийн цахим ур чадварыг дээшлүүлэх 64 удаагийн сургалтаар нийт 2084 иргэн, 40 удаагийн сургалтаар 1769 төрийн албан хаагчдыг хамруулсан. 2. Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах талаарх мэдлэг, мэдээлэл олгох, цахим орчны зохистой хэрэглээг төлөвшүүлэх,олон нийтийн дунд үе тэнгийн дарамт, ялгаварлан гадуурхалтын талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлж, энэ төрлийн хүчирхийлээс урьдчилан сэргийлэх зорилгоор 2023 оны 04 дүгээр сард "НАЙЗ БАЙЯ" үндэсний аяныг ХНХЯам, Дэлхийн Зөн Монгол ОУБ, Харилцаа холбооны зохицуулах хороотой хамтран зохион байгуулсан. https://mddc.gov.mn/mn/12947/</p> <p>Хавсралт : 3 файл</p>	100%	Үгүй		
104	<p>Нэг.10/. цахим баримт бичиг нь цаасан баримт бичгийн нэгэн адил хүчинтэй байх хуулийн зохицуулалтыг хангаж, холбогдох хууль тогтоомж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар арга хэмжээг авах; (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, иргэн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрч, нотлох баримтын хэмжээнд үнэлэх нөхцөлийг бүрдүүлэхээр хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах, зорилго бүхий нийт 120 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн.</p>	100%	Үгүй		
105	<p>Нэг.11/. эрүүл мэндийн, боловсролын болон нийгмийн хамгааллын салбарын цахим шилжилтийн хүрээнд хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрт төрийн аудитын байгууллагаар мэдээллийн технологийн аудит хийлгэх. (Нэг.Цахим шилжилтийн үйл ажиллагааг эрчимжүүлэх зорилгоор дараах арга хэмжээг аач хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т даалгасугай.)</p>	<p>1. Дэлхийн банкны санхүүжилтээр хэрэгжүүлсэн Цахим эрүүл мэнд төслийн хүрээнд хийгдсэн ажлыг дүгнэх зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны яам, "И-Монгол академи" УТУГ, "Үндэсний дата төв" УТУГ, Тагнуулын ерөнхий газрын Кибер аюулгүй байдлын газар, Эрүүл мэндийн яамны хамтарсан ажлын хэсэг 2022 оны 8 сард байгуулагдаж, үнэлэлт дүгнэлт өгсөн. Мөн хөндлөнгийн үнэлгээг эрхзүйн зохицуулалтын шаардлага, Эрүүл мэндийн яамны ерөнхий алсын хараатай нийцэж байгаа эсэхэд дүгнэлт гаргуулсан. 2.Дээд боловсролын сургалтын байгууллагуудад ашиглагдаж буй мэдээллийн систем, программ хангамжид мэдээллийн аюулгүй байдлын үзэлт хийх, харилцан мэдээлэл солилцох боломжийг судлах, зөвлөмж боловсруулах чиг үүрэг бүхий Ажлын хэсгийг БШУ-ны сайдын 2022 оны 12 сарын 13-ны өдрийн А/527 дугаар тушаалаар байгуулсан. Ажлын хэсэгт Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төлөөлөл оролцож, боловсролын салбарын мэдээлэл солилцооны систем бий болгох, мэдээллийн аюулгүй байдлын чиглэлээр тус тус санал, зөвлөмж өгч ажилласан.</p>	70%	Үгүй		

	106		Хоёр. Тогтоолын биелэлтийг Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд багтаан танилцуулахыг Монгол Улсын Засгийн газар (Л.Оюун-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.	Монгол Улсын Их Хурлын Инновац, цахим бодлогын байнгын хорооны 2022 оны "Чиглэл өгөх тухай" 01 дүгээр тогтоолоор цахим шилжилтийг эрчимжүүлэхэд шаардлагатай нийт 11 арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасны дагуу Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганд танилцуулсан.	100%	Үгүй	
17	107	Чиглэл өгөх тухай 2023-03-28 Дугаар 2023№05 НББХ	1.2.3/. Боловсрол, шинжлэх ухааны яамнаас Монголын үндэсний олон нийтийн радио, телевиз, Харилцаа холбооны зохицуулах хороо зэрэг холбогдох байгууллагуудтай 2019 оны 03 дугаар сарын 15-ны өдөр байгуулсан хүүхдийг сэрүүн байх цагаар хүмүүжил төлөвшилд сөрөг нөлөө үзүүлэх тодорхой төрлийн контентыг хязгаарлахтай холбоотой харилцан ойлголцлын санамж бичгийн хэрэгжилтийг хангах, үр дүнг тайлагнах;	Олон суваг дамжуулах үйлчилгээнд хүүхдийг зохисгүй агуулгатай контентоос хамгаалах зорилгоор Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлагын 6 дугаар зүйлийн 6.2.8. дах хэсэгт "Эцэг, эхийн хяналтын функц ашиглах, суваг хаах, түгжих, нууц үг солих зааврыг хэрэглэгчид нээлттэй мэдээлнэ.6.11. дэх хэсэгт "Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах зорилгоор эцэг, эх хяналт хийж (parental control), сувгийг түгжих техникийн боломжийг бүрдүүлнэ" гэж заасныг тус тус үндэслэн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас 2022 оны 09 дүгээр сарын 29-нд уулзалт зохион байгуулж Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчдэд эцэг эхийн хяналт хийх боломжийг бүрдүүлж ажиллахыг үүрэг болгон ажиллаж байна.Түүнчлэн олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэгчид хэрэглэгчдэдээ эцэг, эхийн хяналтын функцийг хэрхэн ашиглах, сувгийг хэрхэн түгжих зэрэг хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахад чиглэсэн шаардлагатай мэдээлэл, зөвлөмжийг ойлгомжтой, тодорхой байдлаар өөрийн цахим хуудас болон үйлчилгээгээрээ дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллахыг үүрэг болгоод байна.	70%	Үгүй	
18	108	Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-04-25 Дугаар 2023№05 ТБХ	2e/. гаалийн орлогыг нэмэгдүүлэх хүрээнд "Шинэ сэргэлтийн бодлого"-н боомтын сэргэлтийн ажлыг эрчимжүүлж экспортыг нэмэгдүүлэх. Гаалийн тухай хууль тогтоомж, боловсон хүчний чадавхыг сайжруулж, гаалийн үйлчилгээний цахимжилтын хамрах хүрээг өргөжүүлэх;	Гаалийн байгууллагын үйлчилгээг цахимжуулж, хилийн боомт, гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах, барааг урьдчилан мэдүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр гаалийн байгууллагаас санал боловсруулсны дараа тус яамнаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу зөвлөмж, дүгнэлт өгч, мөргөжил, арга зүйн удирдлагаар хангах боломж бүрдэнэ.	Х.Б	Үгүй	
	109		3a/. Засгийн газрын гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээ, өмч хөрөнгийн бүртгэл, хэрэгжилт, үр дүнд тавих хяналтыг сайжруулах, хэрэгжиж дууссан төслүүдийн хүрээнд үүссэн өмч, хөрөнгийн бүртгэлийг судлах, зээлийн эргэн төлөлтийн байдал, шинээр авахаар төлөвлөж буй зээлүүдийн эрэлт хэрэгцээг үнэлж, дүн шинжилгээ хийх, үр дүн муутай, хэрэгжилт удаашралтай төслүүд болон шинээр авахаар төлөвлөж буй шаардлагагүй гэж үзсэн зээлийг зогсоох, цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг салбар бүрээр гаргах, танилцуулах;	Монгол улсын 2023 оны төсвийн тухай хуулиар 5 төсөл арга хэмжээнд Цахим хөгжил, харилцаа холбооны Сайдын багцад нийт 21.6 тэрбум төгрөг батлагдсан. Үүнээс 3 төсөл он дамжин хэрэгжиж, нийт 5 төсөл хэрэгжиж байна. шинээр хэрэгжиж байгаа 2 төсөл арга хэмжээ.2023 оны эхний хагас жилийн байдлаар 9 хувийн гүйцэтгэлтэй байна.	70%	Үгүй	
	110		3a/. улирал бүр Засгийн газрын болон улсын секторын өрийн мэдээллийг олон улсын байгууллагаас тогтоосон нэгдсэн стандартын дагуу бэлтгэж, олон нийтэд ил тод мэдээлэх.	Сар, улирал бүр төсвийн гүйцэтгэлийн мэдээг батлагдсан маягтын дагуу бэлтгэж шилэн дансны нэгдсэн цахим хуудас, байгууллагын албан ёсны цахим хуудасаар тус тус нийтэд мэдээлэн ажиллаж байна. http://shilendans.gov.mn	100%	Үгүй	
	111		4a/. төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагуудын биет болон биет бус хөрөнгийг бүртгэх, хянах тогтолцоог сайжруулж, өмчийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн цахим систем бий болгох, нэгдсэн мэдээлэл, дүнг Улсын Их Хурлын холбогдох Байнгын хороодод жил бүр танилцуулахтай холбоотой зохицуулалтыг хууль тогтоомжид оруулах санал бэлтгэх, танилцуулах;	Төрийн өмчийн тооллогын нэгдсэн систем болон Fiscus санхүүгийн программд биет болон биет бус хөрөнгийг бүртгэж, хөрөнгө тус бүрийг коджуулж, хагас жил тутамд хөрөнгийн тооллого зохион байгуулж, тооллогын ажлын хэсэг, өмч хамгаалах зөвлөлийн хурлын шийдвэрийг байгууллагын удирдлагад танилцуулж, ТӨБЗГ-т хүргүүлэн ажиллаж байна.	100%	Үгүй	
	112		4b/. төрийн өмчт болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн бүтэц, орон тоо, зардлын зохистой байдлыг бий болгох, үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, борлуулалтын ил тод байдлыг хангах хүрээнд биржээр дамжуулан борлуулж, ашигт ажиллагааны түвшинг нэмэгдүүлэх, татварын дараах ашгийг хуваарилах, олон нийтийн оролцоог хангасан сайн засаглалтай болгох, төлөвлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүн, гүйцэтгэх захирал, удирдлагын багийн сонгон шалгаруулалтыг нээлттэй, ил тод болгох, тэдний эрх үүрэг, хүлээх хариуцлагыг холбогдох хууль тогтоомжид нарийвчлан зохицуулах санал бэлтгэх, танилцуулах.	Цахим хөгжил,харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил,харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.
	113		6b/. төсвийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор төсвийн талаарх үндсэн баримт бичгийг цаг тухайд нь олон нийтэд цахим хэлбэрээр, иж бүрэн, энгийн ойлгомжтой, төсвийн тоон мэдээлэл нь шинжилгээ хийх, ашиглахад хялбар байдлаар хүргэх;	Цахим хөгжил, харилцаа холбооны яам 2022 оны 01 дүгээр сараас эхлэн Шилэн дансны тухай хууль тогтоомжийн дагуу shilendans.gov.mn цахим төсвийн ил тод байдлыг сайжруулах зорилгоор төсвийн талаарх үндсэн баримт бичгийг цаг тухайд нь олон нийтэд цахим хэлбэрээр, иж бүрэн, энгийн ойлгомжтой мөн төсвийн тоон мэдээлэл нь шинжилгээ хийх, ашиглахад хялбар байдлаар ил тод байршуулан ажиллаж байна. www.shilendans.gov.mn	100%	Үгүй	
114	6г/. төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллах.	Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, хяналтын бүх үе шатанд мэргэжлийн судлаачид, мэргэжлийн төрийн бус болон судалгааны байгууллагуудтай хамтран ажиллаар төлөвлөн ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас	30%	Үгүй			

	115		5а/ аймгуудын өрсөлдөх чадварын индексийг тогтоох аргачлалыг боловсруулан баталж, мөрдүүлж, жил бүр Засгийн газраас Засаг дарга нартай байгуулдаг үр дүнгийн гэрээнд индексийг тусган, биелэлтийг хянаж;	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/14 дугаар тушаалаар байгуулагдсан "Ухаалаг аймаг, сум, хотын жишиг баримт бичиг, шалгуур үзүүлэлтийн төсөл боловсруулах" чиг үүрэг бүхий ажлын хэсгийн хүрээнд аймгийн цахим шилжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг 6 индекс бүхий 74 төрлийн үзүүлэлтэйгээр боловсруулан "Цахим аймаг бодлогын зөвлөмж"-д тусгасан.	100%	Үгүй	
19	116	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2023-06-11 Дугаар 2023№03 ҮБХ	1.2/ Хувьцаагаа нийтэд худалдсан төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хяналт, оролцоог нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлж, Монгол Улсын Их Хурлаас баталсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д нийцүүлэн төрийн өмчит хуулийн этгээдийн үр ашиг, засаглалыг сайжруулах, олон нийтийн шууд хяналтад оруулах ажлын хэрэгжилтийг хангаж;	Хувьцаагаа нийтэд худалдсан төрийн өмчийн оролцоотой нээлттэй хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хяналт, оролцоог нэмэгдүүлж, хувьцаа эзэмшигчдийн эрхийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэхтэй холбоотой асуудлаар Хууль зүй, дотоод хэргийн яам холбогдох эрх зүйн орчныг сайжруулахаар ажиллаж байгаа бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын чиг үүрэгт хамаарахгүй болно.	Х.Б	Тийм	Хууль зүй, дотоод хэргийн яам хариуцан хэрэгжүүлж байгаа болно.
	117		1.3/ Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг 2023 оны 07 дугаар сарын 01-нээс хэрэгжүүлэхтэй холбогдуулан хуульд заасан холбогдох журмуудыг хууль хэрэгжих хугацаатай нийцүүлэн баталж, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах, мөн биржээр арилжаалах уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэн, арилжааг олон улсын жишигт нийцүүлж, нээлттэй, ил тод зохион байгуулах;	Цахим хөгжил харилцаа холбооны яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна. Мөн хариуцан хэрэгжүүлэх байгууллага нь Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хангуулан ажиллах нь зүйтэй байна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил харилцаа холбооны яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна.
20	118	Тогтоолын хэрэгжилтийн талаар 2023-06-13 Дугаар 2023 № УИХ-13/1919	1. Монгол Улсын Их Хурал 2022 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 21 дэх илтгэлийг хэлэлцэж Монгол Улсын Их Хурлын 49 дүгээр тогтоолыг баталсан бөгөөд хэрэгжилтийг Монгол Улсын Их Хурлын 2022 оны намрын ээлжит чуулганы хугацаанд Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасан.	Цахим хөгжил харилцаа холбооны яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил харилцаа холбооны яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна.
Ерөнхийлөгчийн зарлиг							
21	119	Монгол бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-05-23 Дугаар 2018_46	1.. Монгол бичгийн цахим кодыг хэрэглэх үндэсний стандартыг холбогдох мэргэжилтнүүдийн саналыг тусган шуурхай боловсруулж, хуульд заасны дагуу батлуулах, цаашид хөгжүүлэн тогтвортой байдлыг хангаж, цахим орчинд үндэсний хэрэглээг нэмэгдүүлэх талаар бодлого, төлөвлөгөө гарган ажиллахыг Мэдээлэл, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол хэлний тухай хуулиар үүрэг хүлээсэн эрх бүхий судалгааны байгууллагуудад; Үндэсний стандартыг боловсруулах ажилд хяналт тавьж, боловсруулсан стандартыг судалж батлах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, монгол бичгийн цахим кодчллыг олон улсын стандартад үндэсний стандартыг хэлэлцүүлэх, батлуулах ажлыг зохион байгуулахыг Стандартчилал, тохирлын үнлэгээний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон Монгол Улсын Шадар сайдад чиглэл болгосугай.	1. ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгийн дэргэд монгол бичгийн кодчиллын асуудал эрхэлсэн нэгжийг байгуулах талаар тус хүрээлэнтэй хамтран ажиллаж байна. Мөн уг нэгжийг чадавхижуулах, сургалт, хөтөлбөрт хамруулах талаар Юникод консорциум мэргэжилтнүүдийн дэмжлэг, тусламж авах талаар уг консорциумын техникийн хурлын үеэр санал тавьж дэмжсэн хариу аваад байна. "Монгол бичгийн юникод стандартын үсгийн хэлбэр хувирлын сонголтын дүрэм"-ийн төслийг боловсруулж БШУСЯ, СЯ, Стандарт, хэмжилзүйн газар, Монгол Улсын Их сургууль, Монгол Улсын боловсролын их сургууль, ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэн зэрэг байгууллагуудаас саналыг авч нэгтгэсэн. Тус дүрмийн төслийг Юникод консорциумын Техникийн мэргэжилтнүүдийн 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн хуралд танилцуулж хэлэлцүүлсэн. 2. "Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо. Тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдэгтийн байршил" үндэсний стандартын төслийг боловсруулж, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр Монгол бичгийн стандартчилалын дэд хорооны хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. Мөн Стандарт хэмжил зүйн газрын даргын 2023 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн С/17 тоот тушаалаар "MNS 7004:2023, Монгол хэлний компьютерын орчны тогтолцоо. Тооцоолох хэрэгслийн гарын товчлуур дээрх монгол бичгийн үсэг, тэмдгийн байршил" стандартыг үндэсний болгон батлуулсан болно.	100%	Үгүй	
	120		3.. Албан байгууллага, аж ахуйн нэгж, барилга байгууламж, гудамж, талбайн нэр хаяг, бүтээгдэхүүний шошго, бэлгэ тэмдэг, зар сурталчилгаа зэргийг үндэсний бичгээр бичиж хэвшүүлэх ажлыг зохион байгуулах; үндэсний бичгийн хэрэглээг нэмэгдүүлж, түгээн дэлгэрүүлэхэд чиглэсэн уг үйл ажиллагаа, аливаа идэвх санаачилгыг хөхиулэн дэмжиж, урамшуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нар, холбогдох төрийн байгууллагуудад чиглэл болгосугай.	5.1.Монгол бичгийн юникод стандартыг боловсронгуй болгох ажлын хүрээнд кодчилол судлаач иргэн Б.Энхдалайтай хамтран ажиллах гэрээ байгуулж, "Монгол бичгийн юникод стандартын техникийн дүрмийн орчуулга", "Монгол бичгийн юникод стандартын үсгийн хэлбэр хувирлын сонголтын дүрэм"-ийг боловсруулсан. Дүрмийн шинэчилсэн хувилбарын дагуу монгол бичгийн юникодын хүснэгт нь үсгийн тиг (font) байршлаар болон агууламжид (context) үндэслэн автоматаар сонгох 160 хувилбар, - FVS1, FVS2, FVS3, FVS4 удирдах тусгай тэмдэгтээр сонгож өөрчлөх 100 хувилбартай (үүнээс эртний хэлбэрийг тусгасан нь 20 орчим дүрс) болж шинэчлэгдсэн. 5.2 Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны цахим веб сайтын монгол бичгийн хувилбарт 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 35 мэдээ, материалыг хөрвүүлж нийтэлсэн. 5.3.Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших ажлыг 2023 онд хийхээр төлөвлөсөн. 5.4.Яамны албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгыг 2023 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан. 5.5.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон төрийн нарийн бичгийн даргын нарийн хуудсыг монгол бичгээр хэвлэн хэрэглэж байна.	100%	Үгүй	

22	121	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-04-09 Дугаар 2019_60	7. Хүүхдийг цахим орчны халдлагаас хамгаалах тодорхой арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх, үр дүнг үнэлж, хэрэгжилтийг сайжруулах, энэ чиглэлээр хуулийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн мэдүүлэх. Тайлбар: 2022 оны хагас жилийн тайланд хийсэн ХШУ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Тодорхой төлөвлөгөө гаргасан эсэх, хэрэгжилт үр дүнг үнэлж, сайжруулах арга хэмжээ авсан эсэх, энэ чиглэлийн хуулийн төсөл боловсруулагдсан болон санал өгсөн эсэх	Тус яамнаас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлуулсан. Уг хуульд хүүхдийн бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан, хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан, хүүхдийг гуйлга гуйх, тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, уриалсан, өдөөн хатгасан, сурталчилсан контентыг олон нийтийн сүлжээнд нийтлэхгүй, түгээхгүй байхаар, энэ төрлийн контентыг нийтэлсэн, түгээсэн тохиолдолд олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч байгууллагад хандаж контентыг хязгаарлах, мөн урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлуудыг цогц байдлаар зохион байгуулахаар тусгасан. 2023 оны 06 дугаар 14-ны өдөр НҮБ-ын Хүүхдийн сангийн Монгол дахь суурин төлөөлөгчийн газар, Олон улсын цахилгаан холбооны байгууллагын Ази, Номхон далайн бүсийн газар, Харилцаа холбооны зохицуулах хорооноос хамтран "Цахим орчны хүүхэд хамгаалал-2023" үндэсний хэлэлцүүлэгийг хамтран зохион байгуулсан. Хүүхдийг цахим орчноос хамгаалах техник, технологийн хяналт тавих боломжийг бүрдүүлэх, цахим орчны зохистой хэрэглээний талаарх мэдлэг, мэдээллийг дээшлүүлэх, өсвөр үеийнхний цахим орчны төрөл бүрийн халдлага, гадуурхал, дээрэлхэл, цахим гэмт хэргийн золиос болохоос хамгаалах, хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэхэд ЦХХХЯ онцгой анхаарч ажиллахаа уг хэлэлцүүлэгт онцлов. https://mddc.gov.mn/mn/13640/	100%	Үгүй	
23	122	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2019-05-30 Дугаар 2019_104	1.2.. Цахим орчинд тавих хяналтын тухай хууль тогтоомжийг шинээр боловсруулж, нийгмийн сүлжээнд Харилцаа холбооны зохицуулах хороо болон хууль сахиулах байгууллагаас хяналт тавьж, болзошгүй эрсдэлээс сэргийлж, IPTV болон нийтийн мэдээллийн хэрэгсэл, интернетийн сүлжээнд шаардлагтай хягааралтуудыг тухай бүр хийж зохицуулалтыг бий болгох.	"Тус яамнаас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамгаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлуулсан. Уг хуульд хүүхдийн бие махбод, оюун санаа, зан суртахуунд сөргөөр нөлөөлөхүйц дарамт үзүүлсэн, уриалсан, сурталчилсан, хүчирхийлэл, садар самууныг уриалсан, сурталчилсан, хүүхдийг гуйлга гуйх, тэнэмэл, хараа хяналтгүй амьдрахад татан оруулсан, уриалсан, өдөөн хатгасан, сурталчилсан контентыг олон нийтийн сүлжээнд нийтлэхгүй, түгээхгүй байхаар, энэ төрлийн контентыг нийтэлсэн, түгээсэн тохиолдолд олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч байгууллагад хандаж контентыг хязгаарлах, мөн урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлуудыг цогц байдлаар зохион байгуулахаар тусгасан. Мөн хүн, хуулийн этгээдээс эерчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэх механизмыг бүрдүүлж, Кибер халдлага, эерчилтэй тэмдэг нийтийн төвийн олон нийттэй харилцах нэгж нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн агуулга, нөхцөлийг харгалзан хүсэлтийг 72 цагийн дотор хянан шийдвэрлэхээр тусгасан. Монгол Улсад мэдээллийн сүлжээ ашиглан үйлчилгээ үзүүлэхэд тавигдах шаардлага, мэдээллийн сүлжээний нээлттэй байдалтай холбогдсон харилцааг зохицуулах зорилгоор "Мэдээллийн сүлжээ ашиглах, үйлчилгээ эрхлэх зохицуулалтын журам"-ыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос батлан захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэхээр Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудтай 2022 оны 09 дүгээр сарын 29-ний өдөр Цахим орчин дахь хүүхэд хамгааллын чиглэлээр уулзалт зохион байгуулж IPTV болон интернетийн сүлжээнд шаардлагатай хяналтын технологийн тохиргоо хийж чиглэл өгсөн ба уг ажлын хүрээнд Юнивишн ХХК Эцэг эхийн хяналтын функцыг нэмэлтээр оруулж, хүүхдүүд зөвхөн насны ангиллын стандартыг хагасан зөвшөөрөгдсөн суваг, кино контентийг үзэх боломжийг бүрдүүлсэн.	100%	Үгүй	
24	123	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2021-08-27 Дугаар 2021_22	1.3. Хүүхэд бүрт улсын хэмжээний олимпиадад оролцох тэгш боломжийг бүрдүүлэх үүднээс улсын хэмжээгээр бүх сурагчдыг бие даан суралцаж өөрийгөө хөгжүүлэх, олимпиадад бэлтгэх, шинжлэх ухааны чиглэлээр тогтмол сургалт, хэлэлцүүлэг, цахимаар сорил, олимпиадад хамрагдах боломжоор хангасан нэгдсэн цахим дэд бүтцийг хөгжүүлэх, уг цахим дэд бүтцийн үйл ажиллагааны хэвийн, тасралтгүй байдлыг хангахад онцгойлон анхаарах. Тайлбар: Тайланд хийсэн ХШУ-ний дагуу энэхүү заалтыг ирүүлэхдээ дараах зүйлийг анхаарна уу: Цахим дэд бүтцийг бий болгох, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлуудыг тусгах.Цахим дэд бүтцийг бий болгох, үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах чиглэлээр хийсэн ажлуудыг тусгах	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 13 дахь заалтад боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал нь Боловсрол, шинжилгэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах бөгөөд Боловсрол, шинжилгэх ухааны яам хариуцан гүйцэтгэж, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зөвлөмж, дүгнэлт авч, мөргөжил, арга зүйн удирдлагаар ханган ажиллах боломжтой.	Х.Б	Тийм	Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 13 дахь заалтад боловсролын тогтолцоог хөгжүүлэх асуудал нь Боловсрол, шинжилгэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээнд хамаарах тул хяналтаас хасуулах саналтай байна
25	124	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Тэрбум мод/ 2021-10-04 Дугаар 2021_58	2. Энэ зарлигийг хэрэгжүүлэхэд идэвх санаачилгатай оролцож, эх байгалиа хайрлан хамгаалах, мод тарьж ургуулах үйлсэд бодит хувь нэмэр оруулахыг иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагуудад уриалсугай.	2022 оны 05 дугаар сарын 21-ний өдөр Цахим хөгжил, харилцаа холбооны яам болон "И Монгол" академийн хамт олон "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд хаврын бүх нийтийн мод тарих өдрийг тохиолдуулан Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн мод уржүүлгийн "Ногоон хэрэм" төслийн байршилд мод тарьсан. Хавсралт : 1 файл	100%	Үгүй	
	125		2. Төрийн бүх байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, бүх шатны сургалтын байгууллагууд Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны яам Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан болно Хавсралт : 1 файл	100%	Үгүй	

26	126	Эзэн Богд Чингис хааны эш хөргийг хүндэтгэн залах тухай 2022-07-11 Дугаар 2022_159	4. Монгол хүн бүр Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсугай.	Цахим хөгжил харилцаа холбооны яам болон харьяа байгууллагын албан хаагчдыг Их Монгол Улсын гал голомтыг сахиж буйгаа гүнээ ухамсарлан, Эзэн Богд Чингис хааны суу алдар, үйл хэрэг, билиг сургаалыг эрхэмлэн дээдэлж, даган мөрдөж, төрт ёсны үнэт зүйл, өв соёлыг үр хойчдоо өвлүүлэн үлдээж, эв эеэ сахин бататгаж, улс орноо мандуулахад хувь нэмрээ оруулахыг уриалсан. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яам Эзэн Богд Чингис хааны эш хөргийг дээдлэн залсан болно. Хавсралт : 1 файл	100%	Үгүй	
УАБЗ-ийн зөвлөмж							
27	127	Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх тухай 2018-02-05 Дугаар 2018_06/05	1.12. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг ил болон далд хэлбэрээр сурталчилсан хэвлэл мэдээллийн байгууллагын тусгай зөвшөөрлийг цуцлах, цахим сайт, хаягуудыг хориглох, нийт төрлийн сэдэвтэй гэмт хэрэг үйлдэхийг өөгийүүлэн сурталчилсан, үйлдэх аргыг нарийвчлан харуулсан бүх төрлийн кино, нэвтрүүлэг, нийтлэл болон бусад уран бүтээлийг олон нийтэд хүргэхгүй байх арга хэмжээг тухай бүр авах.	"Тус яамнаас Олон нийтийн сүлжээнд хүний эрхийг хамаалах тухай хуулийн төслийг боловсруулж, Монгол Улсын Их Хурлын 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн чуулганы хуралдаанаар батлуулсан. Уг хуульд мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээг уриалсан, сурталчилсан, гэмт хэрэг, зөрчилд тооцогдох үйлдлийг нарийвчлан зааварчилсан, эсхүл гэмт хэрэг, зөрчил үйлдэхийг уриалсан, өдөөн турхирсан, хатгасан, сурталчилсан, дэмжсэн контентыг нийтэлсэн, түгээсэн тохиолдолд олон нийтийн сүлжээний үйлчилгээ эрхлэгч байгууллагад хандаж контентыг хязгаарлах, мөн урьдчилан сэргийлэх, олон нийтийг соён гэгээрүүлэх ажлуудыг цогц байдлаар зохион байгуулахаар тусгасан. Мөн хүн, хуулийн этгээдээс зөрчилтэй контентын талаарх хүсэлтийг хүлээн авч хянан шийдвэрлэх механизмыг бүрдүүлж, Кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нийтийн төвийн олон нийттэй харилцах нэгж нь энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн агуулга, нөхцөлийг харгалзан хүсэлтийг 72 цагийн дотор хянан шийдвэрлэхээр тусгасан. 2022 оны жилийн эцсийн байдлаар ""Монгол Улсын хууль тогтоомжийг зөрчсөн утга агуулгатай контентыг нийтэлсэн тохиолдолд эрх бүхий байгууллагын шийдвэр, дүгнэлтээр веб сайтыг хар жагсаалт /http://black-list.mn/-д оруулж DNS системийн бүртгэлээр Монгол Улсын нутаг дэвсгэрээс хандах хандалтыг хязгаарлах технологийн арга хэмжээ авч байна. Цагдаагийн ерөнхий газрын Хар тамхитай тэмцэх газраас 4 албан хүсэлтээр мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх бодис сурталчилсан гэх 10 контентыг устгуулах хүсэлтийг Alphabet Inc /Youtube/-д хүргүүлсэн.""	70%	Үгүй	
ЗГ-ын тогтоол							
28	128	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томъёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг туршиж; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	"5.1. Монгол бичгийн юникод стандартыг боловсронгуй болгох ажлын хүрээнд колчилог судлаач иргэн Б.Энхдалайтай хамтран ажиллах гэрээ байгуулж, "Монгол бичгийн юникод стандартын техникийн дүрмийн орчуулга", ""Монгол бичгийн юникод стандартын үсгийн хэлбэр хувирлын сонголтын дүрэм"-ийг боловсруулсан. Дүрмийн шинэчилсэн хувилбарын дагуу монгол бичгийн юникодын хүснэгт нь үсгийн тиг (font) байршлаар болон агууламжид (context) үндэслэн автоматаар сонгох 160 хувилбар, - FVS1, FVS2, FVS3, FVS4 удирдах тусгай тэмдэгтээр сонгож өөрчлөх 100 хувилбартай (үүнээс эртний хэлбэрийг тусгасан нь 20 орчим дүрс) болж шинэчлэгдсэн. 5.2 Цахим хөгжил, харилцаа холбооны яамны албан ёсны цахим веб сайтын монгол бичгийн хувилбарт 05 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 35 мэдээ, материалыг хөрвүүлж нийтэлсэн. 5.3.Төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг туршиж ажлыг 2023 онд хийхээр төлөвлөсөн. 5.4.Яамны албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх зорилгыг 2023 оны сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөнд тусгасан. 5.5.Цахим хөгжил, харилцаа холбооны сайд болон төрийн нарийн бичгийн даргын нэрийн хуудсыг монгол бичгээр хэвлэн хэрэглэж байна.	100%	Үгүй	
29	129	Төрийн албан хаагчийн богино хугацааны сургалт зохион байгуулах тухай 2022-04-06 Дугаар 2022_139	3. Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга, хөтөлбөрт 2023 оноос эхлэн уг сургалтыг нэмж тусган батлуулах арга хэмжээ авахыг "Удирдлагын академи" төрийн өмчит үйлдвэрийн газар (Д.Сүрэнчимэг)-т, сургалт зохион байгуулахтай холбоотой зардлыг "Удирдлагын академи"-ийн төсөвт тусгаж байхыг Сангийн сайд Б.Жавхланд, тус сургалтад хамруулах албан хаагчдынхаа зардлыг тухайн жилийн төсвийн төсөлд тусгаж байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт тус тус даалгасугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 3 албан хаагч, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 6 албан хаагч, Ахлах түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 5 албан хаагч, Эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх багц сургалтад 1, нийт 15 албан хаагчийг хамруулсан. Мөн Төрийн албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад төрийн албанд анх томилогдон ажиллаж байгаа 4 албан хаагчийг хамруулахаар холбогдох мэдээллийг хүргүүлээд байна. Хавсралт : 4 файл	100%	Үгүй	

30	130	"Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөө батлах тухай 2022-04-06 Дугаар 2022_143	<p>2. Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт орших "Шинэ Зуунмод" хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хавсралтад заасан бүрдэлтэйгээр баталсугай.</p> <p>2. Батлагдсан ерөнхий төлөвлөгөөний дагуу "Шинэ Зуунмод" хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, инженерийн болон нийгмийн дэд бүтэц, эх үүсвэрийн зураг төслийг боловсруулах болон барьж байгуулахад шаардагдах зардлыг улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, аймаг, нийслэл, хотын хөгжлийн жилийн төлөвлөгөө, улс, орон нутгийн жил бүрийн төсөвт тусгах болон гадаад улс, олон улсын байгууллагын зээл, тусламжид хамруулах, гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдыг татан оролцуулах замаар шийдвэрлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын үүрэг хариуцагч Б.Жавхлан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабаазар, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар нарт даалгасугай.</p>	<p>Эрчим хүчний яамны хэрэгжүүлж буй "Шинэ Зуунмод хотын эхний ээлжийн мэдээлэл холбооны ажил /Төв, Сэргэлэн/" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд Цахим хөгжил, харилцаа холбооны яамны төлөөлөл оролцож ажиллан, төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д 2023 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр нээлттэй тендер зарласан.</p>	70%	Үгүй	
31	131	Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвийн үйл ажиллагааны талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-05-11 Дугаар 2022_187	<p>1.5.. Иргэн, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг хүлээн авах төрийн байгууллагын дуудлагын утсыг нэгтгэх болон цахимаар хүлээн авах техникийн шинэчлэл хийх, түүнд шаардагдах хөрөнгийг тооцож жил бүрийн улсын төсвийн төсөлд үе шаттайгаар тусгаж байхыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Сангийн сайд Б.Жавхлан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт.</p>	<p>Төрийн бүх шатны байгууллагыг суурин холбооны 26xxxxx нэгдсэн дугаарлалт руу шилжүүлэхтэй холбоотойгоор суурин холбоо "Тусгай хэрэглээний сүлжээ"-ний зориулалтаар ашиглах талаар техникийн нөхцөл, боломжийн талаар нэмэлт судалгаа, тооцоолол хийгдэж байна. Тусгай хэрэглээний сүлжээний эдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой саналыг Тагнуулын ерөнхий газраас авсан. Тогтоолын төслийг шинэчлэн боловсруулж байна. Төрийн байгууллагын 13,396-н суурин утсыг нэгтгэн "Иргэд, олон нийттэй харилцах 11-11 төв"-ийн холболтын шугамд холбох техникийн шийдлийг боловсруулсан. Уг асуудлыг Засгийн газрын хуралдаанд танилцуулахаар "2626" лавлагаа, мэдээллийн тусгай дугаар ашиглах тухай" Засгийн газрын хуралдааны тэмдэглэлийн төсөл, танилцуулга, илтгэлийг боловсруулсан. "Иргэний туслах-2626"-г зохицуулалтын өөрчлөлт оруулж "Төрийн байгууллагыг "26" утгвар бүхий нэгдсэн дугаарлалт руу шилжүүлэх тухай" Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүдээс санал авахад бэлэн болсон байна.</p>	70%	Үгүй	
32	132	Журам батлах тухай 2022-05-31 Дугаар 2022_219	<p>2. "Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.</p> <p>2. Энэ журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд үүрэг болгосугай.</p>	<p>"Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам"-ын төслийг боловсруулж, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 219 дугаар тогтоолоор батлуулсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, нийслэлийн засаг даргын тамгын газраас энэ онд хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийтийн мэдээллийн дэд бүтэцэд хамаарах 39 төсөл хөтөлбөрийн мэдээллийг бүртгэсэн.</p>	100%	Үгүй	
33	133	"Цагааннуур" чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэх тухай 2022-11-23 Дугаар 2022_412	<p>2. "Цагааннуур" чөлөөт бүсийг байнгын ажиллагаанд шилжүүлэхтэй холбогдуулан гааль, мэргэжлийн хяналт, дотоодын цэрэг зэрэг төрийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн албадын үйл ажиллагаа явуулах бэлтгэл ажлыг хангуулах чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд Б.Жавхлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар нарт, Цагааннуур тосгоноос чөлөөт бүс хүртэл шилэн кабелийн сүлжээ байгуулах арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд тус тус үүрэг болгосугай.</p>	<p>Цагааннуур тосгоноос Цагааннуур чөлөөт бүс рүү 4 корын багтаамжтай шилэн кабелийн сүлжээ Цагааннуур тосгоны Ерөнхий боловсролын сургуулиас Цагааннуур чөлөөт бүс хүртэл уг чөлөөт бүсийн хөрөнгөөр хийгдсэн шилэн кабелийг байгуулан ашиглаж байгаа тул давахардсан сүлжээ байгуулах шаардлагагүй гэж үзсэн.</p>	100%	Тийм	Сүлжээ байгуулах шаардлагагүй гэж үзсэн тул хасуулах саналтай байна.
34	134	Хууль хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_417	<p>3. Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжиж байгаатай холбогдуулан холбогдох яамдын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих өөрчлөлт оруулах шийдвэрийг боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаландад, энэ тогтоолын 2.3-т заасан улсын байцаагч нарыг яамны зохих бүтцийн нэгжид шилжүүлэн ажиллуулах арга хэмжээ авч ажиллахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд тус тус даалгасугай.</p>	<p>"Мэргэжлийн хяналтын чиг үүрэг салбарын яамдад шилжиж байгаатай холбогдуулан Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж Засгийн газрын хэрэг эрхлэх газарт 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01/253 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Тус яамны Төрийн газрын бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/19 дүгээр тушаалаар Б.Бүрэнжаргал, Д.Даваасамбуу, Х.Шинэцацаг нарыг хяналтын улсын ахлах байцаагчаар шилжүүлэн томилсон. Төрийн албаны зөвлөлийн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны дэргэдэх Салбар зөвлөлөөс Салбарын хяналтын газрын даргын сул орон тооны сонгон шалгаруулалт зарлуулах захиалгыг 2023 оны 04 сарын 12-ны өдрийн 05 дугаар албан бичгээр Төрийн албаны зөвлөлд хүргүүлсэн. Сонгон шалгаруулалт 2023 оны 05 дугаар сарын 11-нд зарлагдаж, салбарын хяналтын газрын даргыг 05 дугаар саарын 22-ны өдөр томилсон болно.</p>	100%	Үгүй	
				Хавсралт : 1 файл			

35	135		5. Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байгаа харьяа төсөвт байгууллага, төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэх бодлогын чиглэл баримталж, үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус үүрэг болгосугай.	Тус яамнаас харьяа байгууллагуудад албан хаагчдынхаа 10-аас доошгүй хувийг орон нутаг руу шилжүүлэхийг чиглэл болгон ажиллаж байна. Одоогоор Цахим хөгжил, харилцаа холбооны яамны газар хэлтсийг хэрхэн санхүү төсвийн бага зарцуулалтаар шилжүүлэн ажиллахыг судалж байгаа бөгөөд байгууллагын албан хаагчид болон харьяа байгууллагын албан хаагчдын ар гэрийн байдал, суурьшсан бус зэргийг судлахаар бэлтгэж байна.	30%	Үгүй	
	136	Хот, хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2022-11-23 Дугаар 2022_419	9. Төрийн байгууллагаас үзүүлж байгаа үйлчилгээнүүдийг нэгтгэж, мэдээлэл солилцооны цахим шилжилтийг нэвтрүүлэх арга хэмжээг эрчимжүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд, холбогдох мэдээллээр хангаж, дэмжлэг үзүүлж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт даалгасугай.	1.Тус яамнаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам, үйлчилгээний жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүд болон Нийслэлийн Засаг даргаас санал авч, эцсийн байдлаар нийт 790 үйлчилгээнээс лавлагаа тодорхойлолт 109, нэг шатлалт үйлчилгээ буюу үйлчилгээний хүсэлтийг хандсан цэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариугаа өгөх боломжтой үйлчилгээ 142, олон шатлалт үйлчилгээ буюу нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх 539 төрлийн үйлчилгээ, үйл ажиллагааны журам, лавлагаа тодорхойлолтын загвар болон товчооны хамт Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 02 дугаар сарын 03-ны 01/278 дугаар албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар төрийн нийт 790 үйлчилгээнээс 440 үйлчилгээг төрийн үйлчилгээний цэг, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна.	70%	Үгүй	Хавсралт : 1 файл
36	137	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах хэмжээний тухай 2022-12-07 Дугаар 2022_448	2. Төсвийн хөрөнгө оруулалтын чиглэлээр дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 2.1.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, төсвийн хөрөнгө оруулалтын сахилга бат, хариуцлага, үр ашгийг сайжруулах зорилгоор төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний зураг төсвийг санхүүжилтийн эх үүсвэр батлагдсан тохиолдолд боловсруулах; 2.2.төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлтийг зарцуулахгүй байх; 2.3.төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг шуурхай зохион байгуулж, батлагдсан санхүүжилтийг төсвийн жилд багтаан бүрэн олгох арга хэмжээг авах; 2.4.Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуульд барилгын материалын үнийн өсөлтийн нэмэгдэл нь батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулах; 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр дамжуулан хэрэгжүүлж ил тод, нээлттэй байдлыг	2.1.2023 оны Төсвийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний барилга байгууламж байхгүй болно. 2.2-2.4. 2023 оны Төсвийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санхүүжих дүн 21,6 тэрбум төгрөгөөр батлагдсан. Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний үнийн өсөлтийг санхүүжүүлэхэд хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний бэлтгэл ажил, зохион байгуулалтыг шуурхай зохион байгуулж, Төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. 2.5.Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, хэрэгжилт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт болон тайлагналтын үйл ажиллагааг Сангийн яамны улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS-www.publicinvestment.gov.mn)-ээр тухай бүрт нь тайлагнаж байна.	100%	Үгүй	
37	138	Жагсаалт батлах тухай 2022-12-14 Дугаар 2022_460	2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан төсөл, арга хэмжээ бүрийн техникийн тодорхойлолт, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, ажлын даалгавар болон бусад шаардлагатай мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт шилжүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Засгийн газрын 2022 оны 460 дугаар тогтоолын хавсралтад заасан "Үүрэн холбооны сүлжээ (Баянхонгор)" төсөл, арга хэмжээний техникийн тодорхойлолт болон тендерийн гүйцэтгэлийг сонгон шалгаруулах үнэлгээний хороонд ажиллах гишүүний мэдээллийг Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн 03/289 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Техникийн тодорхойлолт, үнэлгээний хороонд ажиллах гишүүний мэдээллийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны газрын даргын 2023 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн А/30 дугаар тушаалаар Үнэлгээний хороо байгуулагдаж, 2023 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр гүйцэтгэгч байгууллагыг шалгаруулсан. Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2023 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А-1/1544 дугаар зөвлөмж хүргүүлэх тухай албан бичгийг захиалагч байгууллагад хүргүүлсэн. Төрийн худалдан авах ажиллаганы газраас ирүүлсэн А-1/1544 зөвлөмжийн дагуу 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдөр Мянган өндөр цахир ХХК-тай ЦХХХЯ/202201004 дугаар гэрээг байгуулсан.	100%	Үгүй	

38	139	Мэргэжлийн хяналтын чиг үүргийг салбарын яамдад шилжүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2022-12-21 Дугаар 2022_469	4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан яамдын үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт зохих нэмэлт, өөрчлөлтийг тусган боловсруулж, батлуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгасугай.	"Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт өөрчлөлт оруулахаар Засгийн газрын тогтоолын төсөл боловсруулан, бүх яамдаас санал авч Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 01/253 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор 2022 оны 13 дугаар "Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр" тогтоолын хавсралтад Салбарын хяналтын газрын чиг үүрэгтэй холбоотой нэмэлт, өөрчлөлтийг оруулсан. Хавсралт : 2 файл	100%	Үгүй	
39	140	Улаанбаатар хотын "Шинэ тойрог зам"-ыг барьж байгуулах тухай 2022-12-21 Дугаар 2022_476	5. 5.Авто замын чигийн дагуух ногоон байгууламж, инженерийн болон цахилгааны шугам, сүлжээ, гэрэлтүүлэг, холбооны кабелийг зөөх, шилжүүлэх, хүчигтэх, хамгаалах ажлыг 2023 оны 4 дүгээр сард багтаан зохион байгуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт, уг ажлыг гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт тус тус даалгасугай.	Нийслэлийн худалдан авах ажиллагааны газар Улаанбаатар "Шинэ тойрог зам" барих төслийн 55км автозамын ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний тендерийг Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (tender.gov.mn)-д 2023 оны 04 дүгээр сарын 20-ны өдөр нээлттэй зарласан. Тогтоолын дагуу хийгдэх ажил 2024 оноос хийгдэх эхэлнэ. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих	30%	Үгүй	
40	141	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2022-12-28 Дугаар 2022_488	5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолын хавсралтаар "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт"-ыг, 2022 оны 488 дугаар "Төрийн албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" тогтоол гарсан. Уг тогтоол гарсантай холбогдуулан Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Б/27 дугаар тушаалаар албан хаагчдын цалин, нэмэгдлийг шинэчлэн тогтоосон. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны "Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Б/17 дугаар тушаал гарсан. Уг тушаалыг үндэслэн Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн Б/54 дүгээр тушаалаар тус яамны хэвийн үйл ажиллагааг хангахад туслах чиг үүрэг бүхий үйлчилгээний ангилалд ажиллаж буй 4 албан хаагчийн үндсэн цалинг нэмэгдүүлж тогтоосон. Мөн 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн МУЗГ-ын 213 дугаар тогтоолыг /Цалингийн хэмжээ тогтоох итгэлцүүр, түүнийг хэрэглэх төрийн байгууллагын жагсаалт, орон тооны дэд хязгаар тогтоох тухай/ хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж байна. Хавсралт : 2 файл	100%	Үгүй	
41	142	Агентлаг байгуулах тухай 2022-12-28 Дугаар 2022_499	8. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газар байгуулагдсантай холбогдуулан нийслэл, орон нутгийн "Үйлчилгээний нэгдсэн төв"-ийг нийтийн мэдээллийн дэд бүтэцтэй холбогдож төрийн үйлчилгээ үзүүлэхэд удирдлага, зохион байгуулалтын дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай.	"Төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг - Хилийн чанадад БНСУ-ын Сөүл хот дахь консулын байр, Хөдөлмөр нийгмийн хамгаалалын газар, Бусан хот дахь консулын газар, Австри Улсын нийслэл Вена хот дахь элчин сайдын яам, Энэтхэг Улсын Ерөнхий консулын газар, Сингапур Улсын Консулын газар, Япон Улсын Токио хот дахь Элчин сайдын яам, Осака хот дахь Ерөнхий консулын газар зэрэг 5 улсын нийт 8 байршилд салбарын үйл ажиллагааг эхлүүлсэн. - Нийслэлийн "Улаанбаатар" их дэлгүүр, "И-март" худалдааны төв, "22-ын товчоо" авто худалдааны цогцолбор, "Төв шуудан", "Хан плаза" худалдааны төв, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль, "Жанжин клуб" соёлын ордон, "Улиастайн нэгдсэн зах", "Да хүрээ" авто худалдааны төв, Багахангай дүүрэг, 2-р хорооны байр, Багануур дүүрэг, 4-р хорооны байр, Сонгинохайрхан дүүрэг, "Номин" худалдааны төвийн Баянхошуу салбар, Нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн "Мишээл" салбарт, Чингэлтэй дүүргийн 14 дүгээр хорооны байр, Чингэлтэй дүүргийн нэг цонхны үйлчилгээ, ХУД, 15-р хороо, "И-Март" худалдааны төвд тус бүр 1 салбар буюу нийт 16 салбарын үйл ажиллагааг эхлүүлсэн. - Орон нутагт: Дархан-Уул, Говьсүмбэр, Увс, Баян-Өлгий, Орхон, Хөвсгөл, Завхан, Архангай, Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Булган, Төв, Сэлэнгэ, Өвөрхангай, Өмнөговьд, Хэнтий зэрэг нийт 18 аймагт ХУРДАН цэгийг нээж, үйл ажиллагааг эхлүүлэн удирдлага зохион байгуулалтаар дэмжлэг үзүүлэн ажиллаж байна." Хавсралт : 2 файл	100%	Үгүй	

42	143	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлах тухай 2023-01-11 Дугаар 2023_79	4. Салбар хоорондын уялдаа холбоог хангаж, хяналт шалгалтыг давхардуулахгүй, бүртгэл, хяналтын удирдлагын нэгдсэн цахим системийг шинэчилж, хэвийн, аюулгүй байдлыг ханган хариуцаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.	1. Мэргэжлийн хяналтын байгууллагад ашиглагдаж байсан хяналт шалгалтын бүртгэл мэдээллийн системийн хэвийн найдвартай ажиллагааг хангаж, систем хэрэглэгчдийг удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллаж байна. 2. Мэргэжлийн хяналтын байгууллагад ашиглагдаж, хөгжүүлэгдэж байсан www.shilenkhyanal.gov.mn , www.e-khyanal.gov.mn , www.igov.mn , www.om.inspection.gov.mn , www.khog-khyanal.mn системүүдэд үнэлт, дүнгэлт өгсөн. 3. 2 системийг Эдийн засаг хөгжлийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд тус тус шилжүүлж, Хүнс хөдөө аж ахуйн яам хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдийн бүртгэл хөтөлөх -1, Уул уурхай хүнд үйлдвэрийн яам тэсрэх материал ашиглах хяналтын хуудас, тээвэрлэх хуудас, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийн тайлан хүлээн авах 3 үйлчилгээг www.e-business.mn цахим системд нэгтгэж үйл ажиллагааг эхлүүлсэн. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын цахим бүртгэлийн системийг Хөдөлмөр нийгмийн хамгааллын яаманд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар шууд хүлээлгэж өгөхөөр шийдвэрлэсэн. ТӨБЗГ-аас байгуулсан ажлын хэсгийн дагуу систем хүлээлцэх бэлтгэл ажлыг хангаж байна.	100%	Үгүй	
43	144	"Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргаа байгуулах тухай 2023-02-01 Дугаар 2023_40	4. "Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж, хамтран ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	"Шинэ Хархорум" хотын бүтээн байгуулалтын асуудал хариуцсан захиргааны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, салбар хоорондын уялдааг хангаж ажиллах Ажлын хэсэгт тус яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна. Ажлын хэсгийн 2023 оны 04 дүгээр сарын 14-ний өдрийн хуралдаж "Шинэ Хархорум" хотын байршлын судалгаатай танилцсан. Мөн шинэ хотын холбоо мэдээллийн эх үүсвэр, шугам сүлжээний зураг төсөл боловсруулах ажлыг 2024 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шийдвэрлэх саналыг боловсруулахаар төлөвлөж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Санхүүжилтээс	30%	Үгүй	
44	145	Дүрэм, журам батлах тухай 2023-02-01 Дугаар 2023_42	2. Кибер аюулгүй байдлын зөвлөл, түүний Ажлын албаны үйл ажиллагааны зардлыг 2023 оны батлагдсан төсөв, орон тоондоо багтаан хэрэгжүүлэх, цаашид шаардагдах зардлыг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгуулж байхыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны А35 дугаар тушаалаар Кибер аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын албаны төсвийг тус тус баталсан. Хавсралт : 2 файл	100%	Үгүй	
45	146	Улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_55	1. Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай	Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар батлагдсан улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын багцад нийт 5 төсөл, арга хэмжээ батлагдсан. Хөрөнгийн гүйцэтгэлийн явцтай уялдуулан төсвийн ерөнхийлөн захирагчийн багцын тухайн онд батлагдсан дүнд багтаан хөрөнгийн зохицуулалт хийж, санхүүжүүлж байна.	100%	Үгүй	
46	147		5. Хот, хөдөөгийн сэрлэлтийн зорилтыг хангах зорилгоор харьяа төсөвт байгууллага, төрийн өмчийн үйлдвэрийн газар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой компани, түүний салбар, нэгж болон салбарын нийт албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлыг хэрэгжүүлэхэд зориулан 2023 оны батлагдсан төсвөөс 50.0 (тавин) саяас доошгүй төгрөгийг зарцуулах, цаашид уг зардлыг жил бүрийн улсын төсөвт тусгаж байхыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгосугай.	"Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үндсэн орон тоог бүрдүүлэх зорилгоор Ажлын байрны сул орон тооны зарыг тухай бүр яамны цахим хуудсаар нээлттэй зарлаж, шалгалт авах ажиллагааг зохион байгуулж байна. Яамны үндсэн орон тоог бүрдүүлсний дараа харьяа байгууллага болон салбарын байгууллагуудын албан хаагчдын тодорхой хувийг орон нутагт шилжүүлэх ажлын төлөвлөгөөг гаргахаар ажиллаж байна. Хэрэгжилт удааширсан шалтгаан: Урт хугацааны туршид хэрэгжих	30%	Үгүй	
	148	Хот, хөдөөгийн сэрлэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-02-08 Дугаар 2023_68	7. Шилжин суурьших иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх цахим платформыг үүсгэн, төрийн үйлчилгээг цахимжуулан "Цахим аймаг" болгох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны яам (Н.Учрал), аймгийн Засаг дарга нарт даалгасугай.	1. Шинэ сэрлэлтийн бодлогын хүрээнд 2023 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн "Хөдөөгийн сэрлэлт" чуулганы бэлтгэл ажлыг хангаж, аймгуудын өрсөлдөх чадварын 169 үзүүлэлтээр дашбоард гаргаж танилцуулсан. 2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Шинэ сэрлэлтийн бодлогын хүрээнд хүн, хуулийн этгээдийг нэгдсэн мэдээллээр хангах www.hudui.mn платформыг үүсгэх бэлтгэл ажлыг хангаж, нээлттэй аймаг асуулж, судалгааны сайт (https://sites.google.com/view/research-20230228/home?authuser=1)-ыг үүсгэн, 21 аймгуудын судалгааг авч нэгтгэсэн. 3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 02 дугаар сарын 24-ний өдрийн А/14 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн хүрээнд Олон улсын цахим засаглал, цахим шилжилтийн индексүүдийг судлан "Аймаг, нийслэлийн цахим шилжилтийн тодорхойлох судалгаа"-ны асуулыг боловсруулсан. 4. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн А/53 дугаар тушаалаар "Цахим аймаг" бодлогын зөвлөмж батлуулж, зөвлөмжийг орон нутгийн удирдлагууд, албан хаагчдад сурталчлах ажлыг тухай бүр зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулсан."Цахим аймаг бодлогын зөвлөмж"-ийн талаар Дархан-Уул аймгийн удирдлагууд, албан хаагчид болон бусад холбогдох төр, хувийн хэвшлийн байгууллагад сурталчлан таниулах арга хэмжээг 2023 оны 6 дугаар сарын 23-аас 24-ний өдрүүдэд зохион байгуулсан."Цахим аймаг" бодлогын зөвлөмжийг орон нутгийн удирдлагууд, албан хаагчдад сурталчлах ажлын хүрээнд "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хэрэгжилт, онцлох ажлууд"-ын хэрэгжилтийн явцын талаар "Шинэ сэрлэлтийн бодлого, Анхан шат-2023" зөвлөгөөнд оролцсон аймаг, нийслэл, дүүрэг, сумын Засаг дарга нарт 450 ширхэг номыг тарааж, мэдээллээр ханган ажилласан.	100%	Үгүй	

47	149	Журам, жагсаалт, загвар батлах тухай 2023-03-15 Дугаар 2023_100	2. Журмын хэрэгжилтийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд үүрэг болгосугай.	Төрийн 790 үйлчилгээнээс лавлагаа тодорхойлолт 109, нэг шатлалт үйлчилгээ буюу үйлчилгээний хүсэлтийг хандсан чэгээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн харуугаа өгөх боломжтой үйлчилгээ 142, олон шатлалт үйлчилгээ буюу нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх 539 төрийн үйлчилгээ, үйл ажиллагааны журам, лавлагаа тодорхойлолтын загварын дагуу үйлчилгээ үзүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 790 үйлчилгээнээс 440 үйлчилгээг төрийн үйлчилгээний цэг, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна. https://legalinfo.mn/mn/detail?lawid=16758871589481&showType=1 эдгээр батлагдсан журмын хүрээнд зохион байгуулалт, хяналтыг хэрэгжүүлж байна.	100%	Үгүй	
48	150	Оюутны талаар авах зарим арга хэмжээний тухай 2023-03-29 Дугаар 2023_111	6. Төрийн цахим үйлчилгээний нэгдсэн системд оюутанд зориулсан тусгай цэс бий болгож, номын сан, соёлын зэрэг үйлчилгээ авах, хөнгөлөлт эдлэх боломжийг бүрдүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд нарт даалгасугай.	Оюутны цахим үнэмлэх, их дээд сургууль, коллежид суралцаж байгаа тодорхойлолт, хөнгөлөлт урамшуулал, тэтгэлгийн мэдээллийг харах боломжийг бүрдүүлсэн оюутанд зориулсан тусгай цэсийг Төрийн цахим үйлчилгээний E-Mongolia нэгдсэн системд нэмж 2023 оны 3 дугаар сарын 15-нд хэрэгжээнд нэвтрүүлсэн. 2023 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар Оюутан цэсэд зориулсан мэдээлэл солилцооны сервис 3,548,296 удаа дуудагдаж, их дээд сургуульд суралцаж байгаа тодорхойлолтыг 11,518 удаа авсан байна. www.e-mongolia.mn	100%	Үгүй	
49	151	Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2023-04-05 Дугаар 2023_120	2.4. "Ногоон хөгжлийн сэргэлт"-ийн хүрээнд Монгол орны бүс нутагт тохирсон төрөл зүйл модны үр, хөрсийг бий болгох, тарьж ургуулах технологи дамжуулах, нутагшуулах судалгааны сууриныг аймаг, нийслэлд бүсчлэн байгуулах, усны нөөцийн хадгалалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн цогц судалгаа хийх, ундны усны чанарыг сайжруулах, хаягдал ус цэвэрлэх, усны хэмнэлттэй технологи боловсруулах, байгальд ээлтэй дэвшилтэт технологи, ногоон санхүүжилтийн механизмыг бүрдүүлж, хог хаягдлыг дахин боловсруулах болон электрон хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэр байгуулах, устгалд оруулах технологийн шийдэл бүхий техник эдийн засгийн үндэслэлийг тус тус боловсруулж, танилцуулахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд нарт;	Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд заасны дагуу Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас өөрийн эрхлэх асуудлын хүрээнд "Ногоон хөгжлийн сэргэлт"-ийн ажлыг эхлүүлсний үндсэн дээр тус яамнаас хамтран ажиллах боломжтой юм.	Х.Б	Үгүй	
	152		3. Энэ тогтоолд заасан арга хэмжээг 2024 оноос эхлэн хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг жил бүрийн улсын төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Сангийн сайд Б.Жавхлан, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, холбогдох Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт тус тус даалгасугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.
50	153	Худалдааг хөнгөвчлөх, уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортыг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээний тухай 2023-05-17 Дугаар 2023_178	2.2. Иргэн, хуулийн этгээдэд гадаад худалдаатай холбоотой төрийн үйлчилгээг үзүүлэхэд төрийн мэдээллийн үндсэн системээр дамжуулан авах, солилцох боломжтой мэдээллийг шаардахгүй байх талаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 169 хуулийн 869 зүйл, заалтад заасан "бичгээр" шаардаж байгаа баримт материалыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэн цахим хэлбэрээр гаргуулан авах боломжтой эсэх асуудлыг судалж, судалгааны ажлыг гүйцэтгэсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 04 дүгээр сарын 25-ны 01/905 дугаар албан бичгээр Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх хүсэлтийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Засгийн газрын 2023 оны 04 дүгээр сарын 26-ны өдрийн 18 дугаар хуралдааны тэмдэглэлээр хуулийн төслүүдийг хэлэлцэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, иргэн, хуулийн этгээдийн төрийн байгууллагаас авах үйлчилгээг цахимжуулах, цахим баримт бичгийг хүлээн зөвшөөрөх, нотлох баримтын хэмжээнд үнэлдэг байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор нийт 120 хуулийн 586 зүйл, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулахаар холбогдох хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын гишүүн, Засгийн газрын гишүүн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал 2023 оны 05 дугаар сарын 29-ний өдөр Улсын Их Хурлын дарга Г.Занданшатарт өргөн мэдүүлсэн.Инновац, цахим бодлогын байнгын хорооноос 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр Төрийн үйлчилгээг цахим хэлбэрээр үзүүлэхтэй холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай болон бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хэлэлцүүлгийг төрийн болон төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан. https://mddc.gov.mn/mn/13781/	100%	Үгүй	
	154		6. Энэ тогтоолоор өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлт, хэрэгжилтийн явц, тайлан, мэдээг улирал тутам Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлж ажиллахыг холбогдох байгууллага, албан тушаалтанд даалгасугай.	Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас дээрх тогтоолтой холбоотой хүргүүлэх биелэлт байхгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас дээрх тогтоолтой холбоотой хүргүүлэх биелэлт байхгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байна.

Ерөнхий сайдын захирамж

51	155	Ажлын хэсэг байгуулах тухай 2022-02-07 Дугаар 2022_13	<p>2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга, Цахим гарын үсгийн тухай хуулийн шинэчилсэн найруулга, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн шинэчилсэн найруулга, Кибер аюулгүй байдлын тухай хууль батлагдсантай холбогдуулан бэлтгэл ажлыг хангаж, хуульд заасан холбогдох журмын төслийг боловсруулах Ажлын хэсгийг 1 дүгээр хавсралтаар байгуулж, Ажлын хэсгээс хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар баталсугай.</p> <p>2. Бэлтгэл ажлыг хангаж, холбогдох журмын төслийг 2022 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор танилцуулахыг Ажлын хэсэг (Л.Энх-Амгалан)-т даалгасугай.</p>	<p>1. Цахим багц хуулийн хүрээнд нийт 37 дүрэм, журам, аргачлал батлуулахаас 2023 оны 06 дугаар сарын байдлаар нийт 19 захиргааны акт батлагдаж, 14 актын төсөлд санал авч байна. Үлдсэн 4 журмын төсөл боловсруулагдах шатанд байна.</p> <p>2. Нийтийн мэдээллийн дэд бүтцийн төлөвлөлтийн нийтлэг журам"-ын төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдрийн А/24 дүгээр тушаалаар байгуулсан. Журмын төслийг боловсруулах ажлын хүрээнд Ажлын хэсэг төрийн энтерпрайз архитектурын тухай, ТОГАФ 9.2 стандартыг судалсан.</p> <p>3. Суурь болон төрөлжсөн мэдээллийн санг цахим хэлбэрээр шинээр үүсгэж, бүтцийн өөрчлөлт оруулах, ашиглалтаас гаргах нөхцөл, бүртгүүлэх журмын төслийг боловсруулсан. Үндэсний статистикийн хорооноос улсын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн санд үнэлгээ хийж, метадатаг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай өөрчлөлтийг оруулан 2023 оны 3 дугаар улиралд эцэслэн батлуулахаар төлөвлөсөн.</p>	70%	Үгүй	
52	156	Ажлын хэсэг байгуулах тухай 2023-01-27 Дугаар 2023_19	<p>2. Төрийн байгууллагуудад хэрэгжүүлж байгаа цахим төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, дижитал эдийн засгийг хөгжүүлэх, цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.</p> <p>Ажлын хэсгийн ажлын явц, үр дүнг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т даалгасугай.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 219 дүгээр тогтоолоор "Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам"-ыг баталсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар (нийт 16 яам, 13 агентлаг, 14 аймаг, тэдгээрийн харьяа болон дэргэдэх 106 байгууллагаас мэдээлэл ирсэн)-аас 2022-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийтийн мэдээллийн дэд бүтэцэд хамаарах төсөл хөтөлбөрийн судалгааг хийсэн. Судалгаагаар нийт 357 төсөл, хөтөлбөрийг 997,8 тэрбум төгрөгөөр хийхээр төлөвлөсөн. Журмын дагуу төрийн захиргааны байгууллагуудаас улсын төсвийн хөрөнгө, гадаад улсын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэсэн. Мөн Сангийн яамнаас гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй мэдээлэл технологийн салбарын төслүүдийн мэдээллийг ирүүлснийг бүртгэсэн. Ажлын хэсгийн хурлаас гарсан шийдвэрийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 01/1027 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын 18 гишүүнд хүргүүлсэн.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	70%	Үгүй	
53	157	Ажлын хэсэг байгуулах тухай 2023-01-27 Дугаар 2023_19	<p>2. Төрийн байгууллагуудад хэрэгжүүлж байгаа цахим төсөл, хөтөлбөрийн уялдаа холбоог хангах, дижитал эдийн засгийг хөгжүүлэх, цахим засаглал, цахим шилжилтийг нэгдсэн төлөвлөлттэй хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үйл ажиллагааг эрчимжүүлэх үүрэг бүхий Ажлын хэсгийг дор дурдсан бүрэлдэхүүнтэй байгуулсугай.</p> <p>Ажлын хэсгийн ажлын явц, үр дүнг 2023 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор Засгийн газарт танилцуулахыг Ажлын хэсэг (Н.Учрал)-т даалгасугай.</p>	<p>Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 219 дүгээр тогтоолоор "Нийтийн мэдээллийн дэд бүтэц, төрийн цахим үйл ажиллагаанд хамаарах цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний нэгдсэн бүртгэл хөтлөх журам"-ыг баталсан. Журмын хэрэгжилтийн хүрээнд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар (нийт 16 яам, 13 агентлаг, 14 аймаг, тэдгээрийн харьяа болон дэргэдэх 106 байгууллагаас мэдээлэл ирсэн)-аас 2022-2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийтийн мэдээллийн дэд бүтэцэд хамаарах төсөл хөтөлбөрийн судалгааг хийсэн. Судалгаагаар нийт 357 төсөл, хөтөлбөрийг 997,8 тэрбум төгрөгөөр хийхээр төлөвлөсөн. Журмын дагуу төрийн захиргааны байгууллагуудаас улсын төсвийн хөрөнгө, гадаад улсын хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа цахим төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаарх мэдээллийг нэгтгэсэн. Мөн Сангийн яамнаас гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй мэдээлэл технологийн салбарын төслүүдийн мэдээллийг ирүүлснийг бүртгэсэн. Ажлын хэсгийн хурлаас гарсан шийдвэрийг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 05 дугаар сарын 09-ны өдрийн 01/1027 дугаар албан бичгээр Монгол Улсын Засгийн газрын 18 гишүүнд хүргүүлсэн.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	70%	Үгүй	
3Г-ын хуралдааны тэмдэглэл							

54	158	2021 оны 2 дугаар сарын 10-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2021-02-10 Дугаар 2021_9	<p>XII.2. . Монгол Улсын Ерөнхий сайд харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөлтэй хийсэн уулзалтын дүнгийн талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан:</p> <p>1. "Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд "Мэдээллийн технологийн боловсрол, аутсорсингийн төв"-ийг байгуулах, цаашид удирдан зохион байгуулах. Инновацийн тухай хуулийн дагуу мэдээллийн технологийн гарааны компанид татварын хөнгөлөлт үзүүлэх боломжийг судлах, дээд боловсролын салбарт мэдээллийн технологийн өндөр түвшний мэргэжилтэн бэлтгэх, Шинжлэх ухаан технологийн сангаар дамжуулан мэдээллийн технологийн компанийг дэмжих, "Боловсролын цахим шилжилт" арга хэмжээг хэрэгжүүлэх, Ерөнхий боловсролын сургууль болон сургуулийн өмнөх боловсролын сургалтын хөтөлбөрт мэдээллийн технологийн чиглэлийн сургалтын агуулгыг нэмэгдүүлэх асуудлыг авч үзэх, зохих арга хэмжээ авахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ) нарт даалгав.</p>	<p>1.Япон улсын Жайка МТҮП-тай хамтран ажиллах санамж бичгийг 6.09-ны өдөр байгуулав. Энэхүү санамж бичгийн зорилго нь ЖАЙКА-аас хэрэгжүүлж буй "Монгол Улсын харилцаа холбоо, мэдээллийн технологи, цахим үйлдвэрлэл, гарааны бизнесийг дэмжих талаар мэдээлэл цуглуулах, баталгаажуулах судалгаа"-г хамтран хэрэгжүүлэх, Монголын МХХТ, цахим салбарт тулгамдаж буй асуудлыг хамтран шийдвэрлэхэд чиглэсэн хоёр байгууллагын харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлэх явдал юм. ЖАЙКА, МТҮП хамтран 6.25-7.1-ний өдрүүдэд Японы Токио, Фүкүока хотод Монголын гарааны бизнес эрхлэгчдийн pitch арга хэмжээг зохион байгуулагдав. 2.БНКУ-ын "Astana hub" технологийн парк болон Мэдээлэл технологийн үндэсний парктэй хамтран ажиллах санамж бичгийг 6.09-ний өдөр байгуулсан. ЦХХХЯ-ны сайд Н. Учрал, БНКУ-ын Цахим хөгжил, инноваци, агаар-сансрын үйлдвэрлэлийн сайд Багдат Мусин, технологийн салбарын хөрөнгө оруулагч, Freedom Finance компанийн захирал Тимур Турлов нартай уулзаж, Монгол Улсын мэдээллийн технологийн салбарт хөрөнгө оруулах боломжийн талаар ярилцсан. Түүнчлэн мэдээллийн технологийн гарааны компаниудыг дэмжих хууль эрх зүйн орчныг сайжруулах чиглэлээр хамтран ажиллахаар болсон. 3."ICT EXPO-Mindgolia 2023" үзэсгэлэнгийн хүрээнд олон төрлийн арга хэмжээний зохион байгуулагдаж байгаагаас бүс нутгийн мэдээлэл, харилцаа холбооны хүртээмж, дижитал эдийн засгийн хөгжлийн талаар хэлэлцэх "Хүртээмжтэй дижитал эдийн засгийг бий болгох нь" сэдэвт өндөр түвшний хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Хэлэлцүүлэгт Тажикистан улсын Аж үйлдвэр, шинэ технологийн сайд Исожон Курбонзода, АХБ-ны Хөгжлийн төлөөх технологи хариуцсан захирал, Уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн зөвлөх Томас Эйбэл, ОУХ холбооны нийгэмлэгийн Азийн бүс хариуцсан захирал Ацүко Окуда тэргүүтэй зочид, БНЭУ, БНХАУ, Япон, Итали, Австрали, Лаос, Канад Франц, Их Британи, УИИВУ-ын улсын элчин сайд нар, Амазон, Гүүгл, ДэллНавер, Хуавеи удирдах түвшний төлөөлөгчид болон Монголын төлөөллүүд уг арга хэмжээнд оролцож мэдээлэл солилцов</p> <p>Хавсралт : 2 файл</p>	100%	Үгүй	
55	159	2021 оны3 дугаар сарын 3-ны өдөр 14 дүгээр тэмдэглэл 2021-03-03 Дугаар 2021_14	<p>XII.3. 8. Аялал жуулчлалын салбарт зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, цахим хэлбэрт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)-т;</p>	<p>""Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 03 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар Аялал жуулчлалын цахим шилжилтийн ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсэг аялал жуулчлалын цахим шилжилттэй холбоотой голлох 5 чиглэлээр төлөвлөгөө гарган, үр дүнг танилцуулсан. 1.Аялал жуулчлалын салбарт хэрэглэгчдийн авдаг үйлчилгээг цахимжуулах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулж, улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлдэг тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлийн 2 зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн бөгөөд И-Монголиа порталын тэзвэр логистик, аялал жуулчлал цэсний зорчигч хэсэгт Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудал ирэх, явах нислэгийн мэдээллийг харах үйлчилгээнүүдийг Төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системд нэгтгэсэн. Аялал жуулчлалтай холбоотой нэгдсэн мэдээлэл бүхий цахим платформ нэвтрүүлэх шийдлийг боловсруулан 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн Засгийн газрын ээлжит хуралдаанаар танилцуулсан. Үндэсний Их Баяр наадмын арга хэмжээний тасалбар болон авто машины зөвшөөрлийг борлуулах, олон нийтэд Үндэсний Их Баяр наадмын талаарх мэдээ, мэдээллийг түгээх, дотоодын болон гадаадын иргэдэд үндэсний хэл, бичиг, түүх соёлыг сурталчлан таниулах байнгын ажиллагаатай www.enaadam.mn цахим хуудасны загварыг Нийслэл засаг даргын Тамгын газар, Соёлын яам, Коди ХХК-тай хамтран гаргаж, Үндэсний Их Баяр наадмыг зохион байгуулах хороогоор батлуулж, иргэд тасалбар худалдан авахтай холбоотой хэрэглэгч бүртгүүлэх болон тасалбар баталгаажих үед SMS илгээх үеийн хэрэглэгчдийн нэгэн зэрэг хандалтын тоо нэмэгдэж системд өндөр ачаалал үүсэх үеийн техникийн бэлэн байдлыг ханган ажиллах арга хэмжээ авах талаарх чиглэлийг оператор компаниудад, төлбөр тооцоог Орау, болон Social pay-д хэт ачаалал үүсэх үеийн техникийн бэлэн байдлыг ханган ажиллах арга хэмжээ авсан.</p>	100%	Үгүй	
56	160	2021 оны 8 дугаар сарын 11-ний өдөр 46 дугаар тэмдэглэл 2021-08-11 Дугаар 2021_46	<p>XIII.7. . Эрүүл мэндийн салбарын цахим шилжилтийн ажлын явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан Цахим шилжилтийн асуудлаар Эстони Улсын туршлага, жишиг загварыг ашиглах боломжийг судалж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.</p>	<p>Эрүүл мэндийн яамтай тухайн салбарт хэрэгжсэн болон хэрэгжиж байгаа цахим төсөл, хөтөлбөрийн биелэлт, өнөөгийн тулгамдсан асуудал, шийдвэрлэх боломжийн талаарх уулзалтыг 2022 оны 09 дүгээр сарын 16-ны өдөр зохион байгуулсан. Уулзалтаар 2 яамны зүгээс хамтарсан ажлын хэсэг байгуулж ажиллахаар тогтсоны дагуу Эрүүл мэндийн сайд болон Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 10 дугаар сарын 18-ны А/509/А/60 дугаар хамтарсан тушаалаар Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг байгуулсан. Ажлын хэсэг удирдамжийн дагуу ажиллаж байна. Эрүүл мэндийн цахим шилжилтийн үйл ажиллагаа, Дэлхийн банкны санхүүжилттэй "Цахим эрүүл мэнд" төслийн хэрэгжилтийн талаарх мэдээллийг Эрүүл мэндийн сайд С.Энхболд, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны Цахим хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Билэгдэмбэрэл нар Инновац, цахим бодлогын байнгын хорооны 12 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанд танилцуулсан. Эстони улсын Цахим эрүүл мэндийн (e-Health Record) бүртгэл, цахим түргэн тусламж, цахим жор зэрэг төвлөрсөн мэдээллийн системийн архитектур төлөвлөлт, өөр өөр систем ашиглаж буй үйлчилгээ үзүүлэгчдээс шаардлагатай мэдээллийг солилцох шийдлийн талаар судалсан.</p>	100%	Үгүй	

57	161	2021 оны 9 дугаар сарын 15-ны өдөр 51 дугаар тэмдэглэл 2021-09-15 Дугаар 2021_51	Х.2.2. Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албаны мэдээллийн сан болон төрийн тусгай хэрэгцээнд авсан газрын талаарх мэдээллийг "Орон зайн мэдээллийн сан"-д оруулах, мэдээллийг нийтэд нээлттэй болгох ажлыг эрчимжүүлж, ажлын явц, үр дүнгийн талаар Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Д.Сумъяабазар, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ нарт даалгав.	<p>"1."Аймаг, нийслэл, сум, дүүргийн газрын албаны мэдээллийн санд шуудангийн нэгдсэн кодыг оноох, бүсчлэлийн кодыг нарийвчлан хуваах одоогийн 5 оронтой zip кодыг 9 оронтой болгон өөрчилж, холбогдох шийдвэрийг гаргахаар ажиллаж байна. Аялал жуулчлалын салбарт хэрэглэгчдийн авдаг үйлчилгээг цахимжуулах чиглэлээр арга хэмжээг зохион байгуулж, улсын тусгай хамгаалалттай газрын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад үзүүлдэг тусгай зөвшөөрлийн хугацаа сунгах болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний чиглэлийн 2 зөвшөөрлийг цахим хэлбэрт шилжүүлсэн. Одоогоор төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системд аялал жуулчлалын байгууллагын гэрчилгээ олгох, дээд зэрэглэлийн зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтоох үйлчилгээг цахимжуулах багтгал ажлыг ханган ажиллаж байна.</p> <p>2.Төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монголиа системийн "Логистик, аялал жуулчлал цэс"-ний "Зорчигч" хэсэгт Чингис хаан олон улсын нисэх онгоцны буудалд ирэх, явах нислэгийн мэдээллийг харах үйлчилгээг нэгтгэсэн.</p> <p>3.Засгийн газрын хуралдааны 2021 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 14 дүгээр тэмдэглэлийн XII.3. 8 дахь хэсэгт "Аялал жуулчлалын салбарт зайлшгүй шаардлагатай үйлчилгээг тодорхойлж, цахим хэлбэрт шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Н.Уртнасан, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газар (Б.Болор-Эрдэнэ)"-т тус тус даалгасны дагуу манай яамнаас аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн цахим платформ нэвтрүүлэх талаарх саналыг холбогдох мэдээллийн хамт боловсруулж, Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 04-ний хуралдаанаар хэлэлцүүлсэн. Одоогоор Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас https://www.mongoliatravel.guide/mn цахим хуудсыг хөгжүүлж, байнгын ашиглалтад оруулаад байна.</p>	100%	Үгүй	
58	162	2022 оны 2 дугаар сарын 16-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2022-02-16 Дугаар 2022_11	ХИХ.6.2. "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан Төрийн бүтээмжийг сайжруулах шинэчлэлийг хэрэгжүүлэх, төрийн байгууллага цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх шаардлагыг тогтоох, байгууллага, албан тушаалтан иргэнтэй шууд харьцах замаар үйлчилгээ үзүүлдэг байдлыг халах арга хэмжээг үе шаттай авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны бүх шатны байгууллагад даалгав.	<p>"1.Шинэ сэргэлтийн бодлогын Төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд Төрөөс үзүүлэх үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, хүнд суртлыг бууруулах зорилтын хэрэгжилт, цаашид авах арга хэмжээний талаарх танилцуулгыг бэлтгэж, Төрийн бүтээмжийн үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдөр зохион байгуулагдсан хорооны анхдугаар хурлаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд танилцуулсан.</p> <p>2.Төсвийн тухай хуулийг дагаж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 32.1 дэх хэсэгт "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага" гэж нэмэлт орсны дагуу "Төрийн үйлчилгээний асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага"-ын үйл ажиллагааг эхлүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 2.1.Төрийн бүтээмж, үр ашгийг нэмэгдүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагаанд инновацыг нэвтрүүлж, цахим шилжилтийг дэмжих зорилготой холбогдох асуудлыг боловсруулан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлсэн. Тус хуралдааны үр дүнд "Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай" Ерөнхий сайдын 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн албан даалгавар гарч, тус албан даалгаврын 2 дахь хэсэгт нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө ЦХХХЯ-ны санал зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан. 2.2.Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд олгодог гэрчилгээ, оюуны өмчийн гэрчилгээ, үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ, ашигт малтмалын тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, их дээд сургуулийн болон мэргэшлийн сургуулийн гэрчилгээ, галын аюулгүй байдлын дүгнэлт, үйл ажиллагаа эрхлэх бусад төрлийн зөвшөөрүүдийг нотлох баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлж, түүнийг цахим хэлбэрээр шалган баталгаажуулах боломжийг бүрдүүлэх талаарх судалгаа хийн 152 гэрчилгээ, 303 тусгай зөвшөөрөл, 7 батламж, нийт 462 төрлийн гэрчилгээ байгааг цахим хэлбэрт шилжүүлэх талаар санал боловсруулан "Шинэ сэргэлтийн бодлогын төрийн бүтээмжийн сэргэлтийн хүрээнд хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар" Засгийн газрын хуралдаанд танилцуулсан.</p>	100%	Үгүй	
59	163	2022 оны 3 дугаар сарын 16-ны өдөр 16 дугаар тэмдэглэл 2022-03-16 Дугаар 2022_16	ХҮИИ.2.3. Эмнэлгийн тусламж, үйлчилгээг чирэгдэлгүй, чанартай, хүртээмжтэй, шуурхай хүргэх хүрээнд эрүүл мэндийн салбарт цахим шилжилт хийхэд дэмжлэг үзүүлж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд даалгав;	<p>1.Лавлагаа шатлалын 48 эрүүл мэндийн байгууллага цаг товлох үйлчилгээг дуудлагын нэгдсэн цаг захиалгын 1800-0119 дугаар, төрийн үйлчилгээний нэгдсэн "И-Монголиа" системээр тус тус хүргэж байна. "Цахим эрүүл мэнд" төслийн хүрээнд Анхан шатны 538, лавлагаа шатлалын 48, хувийн 60 гаруй эмнэлэг эрүүл мэндийн статистикийн программ, даатгалын системтэй холбогдон мэдээлэл солилцоноор 49,000 хэрэглэгчийн эрүүл мэндийн цахим карт үүсгээд байна. Бүх нийтийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгийн үйл ажиллагааг цахимжуулах чиглэлээр асуумж бөглөх, шинжилгээний хариу, шинжилгээнд бүрэн хамрагдсан дүгнэлтийг төрийн үйлчилгээний нэгдсэн "И-Монголиа" системээр дамжуулан хүргэж байна.</p> <p>2.Эрүүл мэндийн даатгалын "health.gov.mn" системд түшиглэн эрүүл мэндийн үйлчилгээнд ашиглагдаж буй 4 төрлийн мэдээллийн систем хооронд 13А маягтын мэдээллийг цахимаар бүртгэх, солилцох нэмэлт хөгжүүлэлтийг хийж, анхан шатны 530, лавлагаа шатлалын 334, нийт 864 эмнэлэг цахимаар хүлээн авах, илгээх боломжтой болсон. 13А маягтыг иргэнд хүргэхэд шаардлагатай хөгжүүлэлтийг хийж төрийн цахим үйлчилгээний "И-Монголиа" системд нэгтгэж, "Үйлчилгээ" цэсийн "Эрүүл мэнд" ангилалд 13А цахим маягтыг байршуулсан. 13А маягтад иргэний шинжилгээний мэдээллийг давхар илгээх, насанд хүрээгүй хүүхдийн маягтыг түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь харах, татан авах нөхцөлийг тус тус бүрдүүлсэн. 06.30-ны өдрийн байдлаар/ төрийн үйлчилгээний нэгдсэн системд 16,871 үүссэн байна.</p> <p>3.Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглагдаж буй программ хангамж, мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэн, эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх үүрэг бүхий хамтарсан ажлын хэсгийг 03 сарын 31-ний өдөр байгуулсан.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй программ хангамжууд хооронд нэгдсэн стандартаар мэдээлэл солилцох загвар, техникийн шаардлага бүхий мэдээлэл солилцооны архитектур, шийдлийг боловсруулсан.</p>	100%	Үгүй	

60	164	2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр 21 дүгээр тэмдэглэл 2022-04-08 Дугаар 2022_21	I.1.10. Сонгуулийн автоматжуулсан систем, Улсын Их Хурлын гишүүний халдашгүй бүрэн эрхтэй холбоотой асуудлыг судлан үзэж, Улсын Их Хурал, холбогдох Байнгын хороотой санал солилцож танилцуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт;	Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн 1/123 дугаар албан бичгийн дагуу "Сонгуулийн мэдээллийн систем" хөгжүүлэхэд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1.1, 29.1.2, 29.1.3, 29.1.4, 29.1.5 дахь заалтад тусгасан шаардлагыг хангаж байгаа эсэхийг нягталж, хариу зөвлөмжийг 2022 оны 09 дүгээр сарын 15-ны өдөр Гecm@gec.gov.mt цахим шуудангийн хаягаар хүргүүлсэн.	100%	Үгүй	
61	165	2022 оны 5 дугаар сарын 4-ний өдөр 27 дугаар тэмдэглэл 2022-05-04 Дугаар 2022_27	ХҮИИ.3. . Аялал жуулчлалын нэгдсэн мэдээллийн цахим платформ нэвтрүүлэх талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан аялал жуулчлалын салбарыг дэмжих, гадаадын жуулчдад зориулсан мэдээллийн нэгдсэн цахим платформыг хөгжүүлэхэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, цахим платформыг ашиглалтад оруулж хөгжүүлэх, холбогдох мэдээ, мэдээллийг тогтмол шинэчилж ажиллахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Б.Бат-Эрдэнэ, Соёлын сайд Ч.Номинд тус тус даалгав.	"Аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хорооны 2022 оны 11 дүгээр сарын 7-ны өдрийн 03 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар Аялал жуулчлалын цахим шилжилтийн ажлыг зохион байгуулах дэд ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг баталсан. Ажлын хэсэг аялал жуулчлалын цахим шилжилттэй холбоотой голлох 6 чиглэлээр төлөвлөгөө гаргаж, Аялал жуулчлалыг хөгжүүлэх Үндэсний хороонд танилцуулсан. Олон улсын цахим төлбөрийн хэрэгсэл /PayPal, Stripe, Мир/-ийн талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, нөхцөл байдлын талаарх танилцуулгыг бэлтгэж БОАЖЯ-нд хүргүүлсэн.	70%	Үгүй	
62	166		XX.1.2. Төрийн тусламж үйлчилгээ, лавлагаа мэдээллийн тусгай дугааруудыг нэгтгэн, нэгдсэн системээр мэдээлэл, тусламж үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг судалж, танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ц.Нямдорж, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан нарт даалгав.	Төрийн бүх шатны байгууллагыг суурин холбооны 26xxxxx нэгдсэн дугаарлалт руу шилжүүлэхтэй холбоотойгоор суурин холбоо "Тусгай хэрэглээний сүлжээ"-ний зориулалтаар ашиглах талаар техникийн нөхцөл, боломжийн талаар нэмэлт судалгаа, тооцоолол хийгдэж байна. Тусгай хэрэглээний сүлжээний эдээллийн аюулгүй байдлыг хангахтай холбоотой саналыг Тагнуулын ерөнхий газраас авсан.	70%	Үгүй	
	167	2022 оны 5 дугаар сарын 11-ний өдөр 28 дугаар тэмдэглэл 2022-05-11 Дугаар 2022_28	XX.5. . Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, стандартын талаар Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Хот, суурин газрын ногоон байгууламж, явган зам, дугуйн замын норм, нормативын баримт бичиг, стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, олон улсын жишигт нийцүүлэх, боловсронгуй болгох талаар шаардлагатай арга хэмжээ авч ажиллахыг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Барилга, хот байгуулалтын сайд Б.Мөнхбаатар, Эрчим хүчний сайд Н.Тавинбэх, Зам, тээврийн хөгжлийн сайд Л.Халтар, Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгав;	Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын гэрчилгээ (RFID tag)-ний загвар, техникийн үзүүлэлт, радио давтамжийн зурвасын хуваарилалт, техникийн нөхцөл, шаардлагын талаарх санал, "Зам, тээврийн нэгдсэн систем"-ийн ерөнхий архитектур, мэдээлэл солилцох зарчмыг тодорхойлоход шаардлагатай мэдээллийн жагсаалтыг тус тус гаргаж ЗТХЯ-нд хүргүүлсэн. Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос ирүүлсэн Нийслэл Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах хуулийн төсөл, түгжрэлийг бууруулах ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тус тус санал боловсруулж хүргүүлсэн.	100%	Үгүй	
	168		XX.7. . Цахим гарын үсгийн тухай хуулийн хэрэгжилтийн талаар Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2022 оны 9 дүгээр сард багтаан бүх иргэдийг тоон гарын үсэгтэй болгох, тоон гарын үсгийг хэрэглээнд нэвтрүүлэх чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Боловсрол, шинжлэх ухааны сайд бөгөөд Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгалан, тоон гарын үсгийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга, төрийн болон төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн удирдлагад үүрэг болгов.	Монгол улсын хэмжээнд 06 сарын 26-ний байдлаар нийт 700006 тоон гарын үсгийг иргэн болон хуулийн этгээдэд олгосон байна. Үүнээс Улсын бүртгэлийн ерөнхий газар 581,930, тоон гарын үсгийн гэрчилгээ олгох тусгай зөвшөөрөлтэй 4 компани 103,827 тоон гарын үсгийг олгоод байна. Тоон гарын үсгийг хэрэглээг нэмэгдүүлэх үүднээс иргэнийг цахим харилцаанд таньж баталгаажуулах, төрийн үйлчилгээний системд нэвтрэхэд тоон гарын үсэг ашиглах боломжийг бүрдүүлсэн. Иргэн, хуулийн этгээд тоон гарын үсэг ашиглан танил, нэвтрэлтийн систем ашигладаг төрийн 50 байгууллагын 99 систем, хувийн хэвшлийн 123 байгууллагын 138 системээр дамжуулан цахим хэлбэрээр үйлчилгээ авч байна. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны А/26 дугаар тушаалаар "Төрийн албан хаагчид гэрчилгээ олгох, түүнийг түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгохтой холбогдсон харилцааг зохицуулах журам", 2022 оны А/30 дугаар тушаалаар "Нийтийн түлхүүрийг гэрчилгээжүүлэх, гэрчилгээ олгосон, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон тухай мэдээллийг агуулсан гэрчилгээний үндэсний санг бүрдүүлэх журам", 2022 оны А/81 дүгээр тушаалаар "Тэрчилгээжүүлэх үйл ажиллагааны журамд тавигдах шаардлага"-ыг тус тус баталж, улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн. Хавсралт : 1 файл	70%	Үгүй	

63	169	2022 оны 8 дугаар сарын 24-ний өдөр 42 дугаар тэмдэглэл 2022-08-24 Дугаар 2022_42	ХҮ.3. . Хүн амыг нас, хүйс, эрүүл мэндийн эрсдэлд суурилсан зонхилон тохиолдох халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд хамруулах үйл ажиллагааны явцын талаар Эрүүл мэндийн сайд С.Энхболд Засгийн газрын гишүүдэд танилцуулав.	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 12 дугаар сарын 06-ны А/129 дүгээр тушаалаар Албан хаагчдын ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөр батлагдаж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд заасны дагуу даатгуулагчийн урьдчилан сэргийлэх үзлэгийн багцын хүрээнд нийт 76 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт 2022 оны 12 дугаар сарын 05-наас 09-ний өдөр Улсын хоёрдугаар төв эмнэлэгт хамруулсан.	100%	Үгүй	
64	170	2022 оны 9 дүгээр сарын 5-ны өдөр 44 дүгээр тэмдэглэл 2022-09-05 Дугаар 2022_44	II.2. Их өгөгдлийн (big data) сан байгуулах, мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгох талаар Үндэсний статистикийн хороотой хамтран холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд нарт даалгав.	1. Төрийн нээлттэй өгөгдлийн нэгдсэн систем (www.opendata.gov.mn)-д 05 дугаар сарын байдлаар 57 байгууллагын 701 нээлттэй өгөгдлийн бүрдлийг байршуулсан. www.opendata.gov.mn 2. Судалгааны нэгдсэн платформийг хөгжүүлэн хэрэглээнд нэвтрүүлэн 74 байгууллагын 1010 судалгааг байршуулсан. www.sudalгаа.gov.mn 3. Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Үндэсний статистикийн хорооны даргын хамтарсан ажлын хэсэг мета өгөгдөл, өгөгдлийн стандарт болон бусад улсад ашиглагдаж буй метадата платформийг судалсан. Мөн Азийн хөгжлийн банктэй хамтран 2023 оны 3 дугаар улиралд багтаан улсын хэмжээнд ашиглагдаж буй мэдээллийн санд үнэлгээ хийх, метадатаг тодорхойлохоор төлөвлөсөн.	100%	Үгүй	
65	171	2022 оны 9 дүгээр сарын 14-ний өдөр 45 дугаар тэмдэглэл 2022-09-14 Дугаар 2022_45	I.2. Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлэх, аюулгүй байдлыг хангах асуудлыг судалж, зохих арга хэмжээ авах саналаа танилцуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав.	Төрийн байгууллагын албан хэрэг хөтлөлтөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлсэн тухай арга хэмжээний танилцуулгыг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн гарын хуралдаанд танилцуулан 58 дугаар тэмдэглэл гаргуулсан. DocX албан бичиг солилцооны дундын системийг хөгжүүлэн Аблессофт, ер.e-mongolia.mn, Digital office, Veritech ер зэрэг системүүдтэй холболт үүсгэснээр төрийн нийт 2743 орчим байгууллага, хувийн хэвшлийн нэвтрүүлсэн "e-doc", "Able" зэрэг албан бичиг солилцооны системд төрийн 1382 орчим байгууллага хоорондоо мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлсэн. Үүнээс 846 байгууллага дундын системд токенор холбогдон нийт 12,900 бичгийг 16,400 хавсралт файлын хамтаар илгээж, 23,200 бичиг хүлээж аваад байна (06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар). Албан бичиг солилцооны дундын систем ашиглалтын талаар сургалтыг бүх яамдын бичиг хэрэг болон мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдад 05 дугаар сарын 19-ны өдөр, бүх агентлагийн бичиг хэрэг болон мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдад 05 дугаар сарын 23-ны өдөр тус тус танхимаар зохион байгуулсан бөгөөд нийт 100 гаруй албан хаагч хамрагдсан. Тус сургалтыг 05 дугаар сарын 22, 24-ний өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд төрийн захиргааны 590 гаруй албан хаагч хамрагдсан байна. https://ema.gov.mn/archives/3505	100%	Үгүй	
	172		XX.4.2. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг "Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал"-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Иргэний нисэхийн ерөнхий газар (С.Мөнхнасан), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т даалгав;	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2022 оны 53 дугаар тушаалаар Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг "Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал"-ын Зорчигч үйлчилгээний барилгын тодорхой хэсэгт байршуулахтай холбоотой тооцоо, судалгааг хийж, нүүлгэн шилжүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хэсэг байгуулагдсан. Ажлын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг "Буянт-Ухаа Олон улсын нисэх буудал"-ын Зорчигч үйлчилгээний барилгад шилжүүлэхтэй холбоотойгоор тус барилгын зориулалт өөрчлөх, технологийн шийдэл гаргах чиг үүрэг бүхий "дэд ажлын хэсэг" Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2022 оны 09 дүгээр сарын 26-ны өдрийн А/56 дугаар тушаалаар байгуулагдан ажилласан ба уг ажлын хэсгээс шаардлагатай төсвийн тооцоолол болон тохижилт, засварын загварыг боловсруулан Ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан. Түүнчлэн тогтоолд дурдагдсан байгууллагын удирдлага холбогдох албан хаагчидтай уулзаж боломжуудыг судлахад нүүхэд гарах зардал өндөр, байгууламжийн эзэмшлийг шилжүүлэх боломжгүй, цаашид ашиглалтын зардал одоо байгаа зардлаас хэт өндөр тул нүүлгэн шилжүүлэх ажлыг дээрх зардлуудыг шийдэгдэх хүртэл тодорхойгүй хугацаагаар хойшлодоод байна.	70%	Үгүй	
	173		XX.4.3. Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэн шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог нарийвчлан гаргаж, улсын 2023 оны төсвийн төсөлд тусгах арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Сангийн сайд Б.Жавхлан нарт даалгав;	Цахим хөгжил, харилцаа холбооны яам, түүний харьяа болон салбар байгууллагыг нүүлгэхтэй холбоотойгоор шилжүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг жигдрүүлэх, байр ашиглахад шаардагдах зардлын тооцоог эхний байдлаар гарган Ажлын хэсгийн ахлагчид танилцуулсан. Тус байгууламжид яамны болон харьяа байгууллага нүүхэд ашиглалтын болон захиргааны зардал хэт өндөр бөгөөд зөвхөн засварын зураг төсөв гүйцэтгэх зардалд 698сая, Кибер халдлага зөрчилтэй тэмцэх нийтийн төвийг байршуулах зардал 2.6 тэрбум орчим төгрөг гарахаар тооцоолсон болно. Иймд холбогдох зардлыг улсын төсөвт тусгуулах боломжгүй болсон.	70%	Үгүй	

66	174	2022 оны 9 дүгээр сарын 22-ны өдөр 46 дугаар тэмдэглэл 2022-09-22 Дугаар 2022_46	Х.1. Батлан хамгаалахын сайдын эрхлэх асуудлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газрыг шилжүүлэх, Цахим хөгжил, харилцаа холбооны яамны харьяанд Улсын бүртгэлийн ерөнхий газрыг шилжүүлэх боломжтой эсхийг судлан үзэхийг Монгол Улсын Шадар сайд С.Амарсайхан, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	Улсын Бүртгэлийн Ерөнхий газрыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын эрхлэх асуудлын хүрээнд шилжүүлэх асуудлаар Ерөнхий сайдад танилцуулга хийсэн бөгөөд Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийг дагалдуулан Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газрыг шинээр байгуулан салбар хоорондын уялдаа холбоог ханган ажиллаж байна.	100%	Үгүй	
67	175	2022 оны 9 дүгээр сарын 28-ны өдөр 47 дугаар тэмдэглэл 2022-09-28 Дугаар 2022_47	IX.1.12. "Зам, тээврийн удирдлагын ухаалаг систем"-ийн бүрэлдэхүүн болох автотээврийн хэрэгслийн гэрчилгээг цахимжуулах ажлыг 2023 оны I дүгээр улиралд багтаан зохион байгуулж, мөн оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс дагаж мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга Ж.Сүхбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	1.Зам тээврийн хөдөлгөөний удирдлага хяналтын нэгдсэн ухаалаг систем"-ийг бий болгох ажлын хүрээнд шаардлагатай төрөлжсөн мэдээлэл сан бүрдүүлэх, салбарын мэдээлэл хариуцагч байгууллагын мэдээллийн сан хооронд мэдээлэл солигдох дэд систем бий болгох чиглэлийг Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг Цахим хөгжил, мэдээллийн технологийн газарт 2023 оны 03 дугаар сарын 31-ний 03/700 дугаар албан бичгээр хүргүүлсэн. 2.Нийтийн тээврийн хэрэгсэлд RFID таг суурилуулах ажлыг Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газар хариуцан хэрэгжүүлж байна.	70%	Үгүй	
	176		IX.1.13. Цахим гэрчилгээгүй автотээврийн хэрэгслийг 2023 оны 4 дүгээр сарын 3-ны өдрөөс эхлэн Улаанбаатар хотын авто замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх арга хэмжээ авахыг Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, аймгийн Засаг дарга нарт;	Нийтийн тээврийн хэрэгсэлд RFID таг суурилуулах ажлыг Нийслэлийн цахим хөгжил, мэдээллийн технологийн газар хариуцан хэрэгжүүлж байна.	70%	Үгүй	
68	177	2022 оны 10 дугаар сарын 5-ны өдөр 48 дугаар тэмдэглэл 2022-10-05 Дугаар 2022_48	XII.1.2. Дараахь арга хэмжээг хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгав: 2.1. Эрхлэх асуудлын хүрээнд стандарт, техникийн зохицуулалтын талаарх олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд; 2.2. "Үзлэгийн мөрөөр авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 2019 оны 6 дугаар сарын 19-ний өдрийн 235 дугаар тогтоолын хэрэгжилтийг дүгнэж, салбарын шаардлагатай стандарт, техникийн зохицуулалтыг 2022 онд багтаан боловсруулж, батлуулахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд;	1.Цахим аймаг, хотын хөгжлийн жишиг загвар, тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлт боловсруулан 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Төрийн нарийн бичгийн даргаар батлуулсан. Тус ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 7.3 дахь хэсэгт заасны дагуу Грийн Визард ХХК, Сорсинг ХХК, Си Икс Плас ХХК-г холбогдох мэдээллээ ирүүлэх тухай 2022 оны 11 дүгээр сарын 27-ны 05/2044 дүгээр албан бичгийг хүргүүлсэн. 2.Банкны холбоо болон 12 арилжааны банкны мэдээллийн технологийн албан хаагчдад "lavlagaa.e-mongolia.mn" системийн ашиглалтын талаарх сургалтыг 2022 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр зохион байгуулсан. Мөн Хүн, хуулийн этгээд үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэхдээ мэдээллийн эзний зөвшөөрлөөр хязгаарлалттай мэдээлэлд хандах, төрийн үйлчилгээний нэгдсэн системээс гарах лавлагаа, тодорхойлолтыг файл хэлбэрээр авах боломжийг бүрдүүлж lavlagaa.e-mongolia.mn системийг хөгжүүлсэн. "Үндсэн систем (ХУР)-ийг ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ"-ний 8.2 дахь хэсгийг үндэслэн "Үндсэн систем ашиглан үйлчилгээ үзүүлэх нэмэлт гэрээ" байгуулсан. 3. Монгол Улсын Шадар сайд, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын хамтарсан 81/А/69 дүгээр тушаалаар байгуулагдсан ажлын хэсгээс "Төрийн үйлчилгээг операторын горимоор үзүүлэхэд тавих ерөнхий шаардлага"-ын стандартыг боловсруулж, Техникийн хорооны хурлаар хэлцүүлж, стандарт, хэмжил зүйн газрын 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн С/51 тушаалаар MNS 6984:2022 баталсан. Хавсралт : 3 файл	100%	Үгүй	
69	178		XII.5. . "Үндэсний дата төв" УТУГ-ын үйл ажиллагаанд үзлэн (Cloud) систем нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгав;	1.Төрийн клауд системийн программ хангамжийн тендерийн үр дүн гарсан. Дэд бүтэц, тоног төхөөрөмжийн тендерт ирүүлсэн баримт бичигт үнэлгээг хийгдэж байна. Төрийн клауд дэд бүтцийн сүлжээ, системийн тохируулга болон суурилуулалтын бэлтгэл ажлыг эхлүүлсэн. 2.Төрийн клауд системийн, програм хангамжийн лиценз худалдах худалдан авах УДТ/202301008 дугаар гэрээг "ФИБО ГЛОБАЛ" ХХК-тай, Төрийн клауд дэд бүтцийн сервер тоног төхөөрөмж худалдах худалдан авах УДТ/20230235 дугаар гэрээг "Саммит компьютер технологи" ХХК-тай тус тус байгуулж https://mcloud.gov.mn домэйн хаяг бүхий "Төрийн клауд дэд бүтэц"-ийн программ хангамжийн суурилуулалтын ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%	Үгүй	
	179	2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49	XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг "Үндэсний дата төв" УТУГ-ын үзлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.	"1.Төрийн байгууллагын сервер тоног төхөөрөмжийн судалгааг хийхээр (https://admin.gov.mn/) домэйн хаягаар хандаж, албаны цахим шуудангийн хаягаар бүртгэл үүсгэн, өөрийн болон харьяа байгууллагын сервер тоног төхөөрөмжийн мэдээллийг тодорхойлох тухай 01/1940 дугаар албан бичгийг 2022 оны 11 дүгээр сарын 07-ны өдөр Засгийн газрын гишүүд, аймаг, Нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн бөгөөд 2022 оны 11 дүгээр сарын 24-ний байдлаар 35 байгууллага бүртгэлээ баталгаажуулж, 11 байгууллага 15 сервер, 6 сүлжээний төхөөрөмж бүртгүүлсэн байна. Үндсэн үйлчилгээний системүүд, дотоод үйл ажиллагаанд ашигладаг системүүд, төрийн зохиомол серверийн дэд бүтэц дээр үүссэн 815 зохиомол серверүүдийн нөөцлөл хийсэн. 2.Төрийн 6 байгууллагын 18 тоног төрөөхөмжийг төрийн зохиомол сервер болон төрийн клауд дэд бүтэцэд нэгтгэх, боломжийг бүрдүүлж, Төрийн зохиомол серверийн дэд бүтэцэд 7 серверийг нэгтгэж, Төрийн байгууллагуудаас ирсэн цахим систем байршуулах хүсэлтийн дагуу 14 байгууллагад, 122 зохиолмол серверийг нөөцийг олгосон. 3."Авто тээврийн үндэсний төв"-ийн сервер, тоног төхөөрөмжийг "Төрийн клауд дэд бүтэц"-д нэгтгэх ажлыг хийж гүйцэтгэсэн.	100%	Үгүй	

70	180	2022 оны 10 дугаар сарын 19-ний өдөр 50 дугаар тэмдэглэл 2022-10-19 Дугаар 2022_50	XII.3.2. Хилээр нэвтэрсэн болон улсын бүртгэл, нийгмийн даатгал, татварын байгууллагад бүртгэгдсэн гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдтэй холбоотой дундын мэдээллийн санг бий болгох талаар зохих арга хэмжээ авахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав.	Эдийн засгийн хөгжлийн яам хөрөнгө оруулагчдад зориулсан e-invest цахим үйлчилгээний нэгдсэн "e-invest" порталыг 2019 оноос хэрэглэнд нэвтрүүлсэн. Уг порталд гадаадын хөрөнгө оруулалттай ААН байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, татварын тооцоотой эсэх, хуулийн этгээдийн дэлгэрэнгүй лавлагаа, хөрөнгө оруулагчийн тодорхойлолт авах үйлчилгээг байршуулсан. Мөн В1 ангиллын визийн зөвшөөрөл хүсэх, В1 төрлийн оршин суух зөвшөөрөл сунах үйлчилгээг цахимжуулсан. Цахим үйлчилгээний "И-Монголиа" системд тодорхойлолт, зөвшөөрөл олгох, сунах үйлчилгээг нэтгэсэн. Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газартай мэдээлэл солилцох чиглэлээр гэрээ байгуулсан бөгөөд нууцад хамаарах мэдээлэлтэй холбоотойгоор гэрээнд нэмэлтээр тусгах ажил хийгдэж байна. "e-invest" порталд нэмэлт хөгжүүлэлт хийхэд төсөв шаардлагатай.	70%	Үгүй	
71	181		XXI.1.2. Гадаад валютын нөөц бүрдүүлэх чиглэлээр төрийн өмчит аж ахуйн нэгжүүд санаачилгатай ажиллах, валютын гарч буй урсгалыг бууруулах зорилгоор шаардлагагүй худалдан авах ажиллагаа болон гадаад томилолтыг хориглох, төсвийн хөрөнгөөр шинэ жилийн баяр тэмдэглэхгүй байх, орон тоог бууруулах, урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, агентлагийн дарга нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага, тэдгээрийг томилох эрх бүхий этгээдэд;	Цахим хөгжил, харилцаа холбооны яам нь төсвийн хөрөнгөөр шинэ жилцагаан сар, эх үрсийн баяр тэмдэглэхгүй бөгөөд урсгал зардлыг хэмнэх арга хэмжээ авч ажиллаж байна.	100%	Үгүй	
	182	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	"Төрийн байгууллагын албан хэрэг хөтөлгөд цахим хэлбэрээр баримт бичиг солилцох нөхцөл бүрдүүлсэн тухай" арга хэмжээний танилцуулгыг 2022 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулан 58 дугаар тэмдэглэл гаргуулсан. DocX албан бичиг солилцооны дундын системийг хөгжүүлэн Аблессофт, ер.e-mongolia.mn, Digital office, Veritech ер зэрэг системүүдтэй холболт үүсгэснээр төрийн нийт 2743 орчим байгууллага, хувийн хэвшлийн нэвтрүүлсэн "e-doc", "Able" зэрэг албан бичиг солилцооны системд төрийн 1382 орчим байгууллага хоорондоо мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлсэн. Үүнээс 846 байгууллага дундын системд токенор холбогдон нийт 12,900 бичгийг 16,400 хавсралт файлын хамтаар илгээж, 23,200 бичиг хүлээж аваад байна (2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар). Албан бичиг солилцооны дундын систем ашиглалтын талаар сургалтыг бүх яамдын бичиг хэрэг болон мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдад 2023 оны 05 дугаар сарын 19-ны өдөр, бүх агентлагийн бичиг хэрэг болон мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдад 2023 оны 05 дугаар сарын 23-ны өдөр тус тус танхимаар зохион байгуулсан бөгөөд нийт 100 гаруй албан хаагч хамрагдсан. Тус сургалтыг 2023 оны 05 дугаар сарын 22, 24-ний өдрүүдэд цахим хэлбэрээр зохион байгуулсан бөгөөд төрийн захиргааны 590 гаруй албан хаагч хамрагдсан байна. https://ema.gov.mn/archives/3505 Хавсралт : 1 файл	100%	Үгүй	
	183		XXI.6.2. Төрийн байгууллагын албан хэрэг хөтөлмөлийн цахим системийн аюулгүй байдлыг хангаж, кибер халдлага, зөрчлөөс сэргийлж ажиллахыг Тагнуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т, цахим системийн хэвийн үйл ажиллагааг хангаж ажиллахыг "И-Монгол академи" УТУГ-ын захирал Л.Энхбатад тус тус даалгав.	Албан бичиг солилцооны дундын системийн шинэчилсэн хувилбарыг Next js, Nuxt js, Tailwind css, Element ui технологид дээр хийж 01 дүгээр сарын 23-ны өдөр нэвтрүүлсэн. Ингэснээр системд холбогдсон байгууллагуудын мэдээллийг үнэн зөв, давхардалгүй бүртгэж ХУР системтэй мэдээлэл солилцох боломж бүрдсэн. Мөн албан хэрэг хөтөлмөлийн системээс токен холболтоор холбогдсон байгууллагуудын мэдээллийг харуулах боломжтой болсон. Албан бичиг солилцооны дундын системд холбогдох байгууллагуудад зориулан гарын авлага боловсруулж https://docx.gov.mn систем дээр байршуулсан. Байгууллага тус бүрээр албан бичиг солилцооны дундын систем ашиглан үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулахыг үйлчилгээний нөхцөлийг зөвшөөрөх хэсгийг байгууллагын бүртгэл хэсэгт тусгасан. Хэрэглэгчийн интерфэйсийг хүртээмжтэй, ойлгомжтой байдлаар шинэчилсэн. Мөн системийн шинжилгээ, хийж бичиг баримтыг цэгцэлсэн болно. Мэдээллийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 2023 оны 03 сарын 10 -ны өдрийн 01/75 тоот албан бичгээр "Эрсдэлийн үнэлгээ хийлгэх тухай" албан бичгийг Тагнуулын ерөнхий газарт хүргүүлсэн. ТЕГ-ын МАБГ-аас үзлэг хийж 6 эрсдэл илгүүлсэн ба эрсдэлтэйд тооцогдсон ажлуудыг 90 хоногийн хугацаанд аригтахаар ажиллаж байна.	70%	Үгүй	
72	184	2022 оны 12 дугаар сарын 12-ны өдөр 60 дугаар тэмдэглэл 2022-12-21 Дугаар 2022_62	ХҮ1.1. . "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хөгжлийн төслүүдийн хэрэгжилтийн явцын талаар Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан "Шинэ сэргэлтийн бодлого"-ын хөгжлийн төслүүдийн судалгаа, тооцооллыг хийж, эдийн засгийн болон нийгмийн ач холбогдлоор нь эрэмбэлэх, "Шинэ сэргэлтийн бодлого"-ын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөгжлийн төслийн жагсаалтаас хасах шаардлагатай төслийн саналаа тодорхой үндэслэл, судалгаатай боловсруулж Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхийг Засгийн газрын гишүүдэд даалгав.	"Шинэ сэргэлтийн бодлого"-ын баримт бичигт тус яамнаас хариуцан хэрэгжүүлэх арга хэмжээг тухай бүр тайлагнан ажиллаж байгаа бөгөөд төслийн жагсаалтаас хасах шаардлагатай санал одоогоор байхгүй байна. Хавсралт : 2 файл	100%	Үгүй	

73	185	2023 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр 5 дугаар тэмдэглэл 2023-01-25 Дугаар 2023_5	X.1.2. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9.6.5-д заасны дагуу Улсын Их Хурлын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай болон хангалтгүй биелэгдэж буй арга хэмжээг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. Монгол Улсын хөгжлийн 2023 оны эхний хагас жилийн төлөвлөгөөний биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 01/1294 дугаар албан бичгээр хүргүүлсэн. "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл" бодлогын баримт бичгийг эрхлэх асуудлын хүрээ, тухайн салбарт хэрэгжүүлэхээр Цахим хөгжил, харилцаа холбооны яамны стратеги, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	100%	Үгүй	
	186		X.1.3. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгасан зорилго, зорилгыг тухайн салбарт хэрэгжүүлэх төлөвлөгөөг боловсруулахдаа өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах арга хэмжээ, үйл ажиллагаа, тэдгээрийн тухайн оны хэрэгжилтийн шалгуур үзүүлэлт, хүрэх (зорилгот) түвшинг урьдчилан тодорхойлж, байгууллагын үйл ажиллагааны жилийн төлөвлөгөөнд тусгах, бусад төрийн захиргааны төв байгууллагын арга хэмжээтэй уялдуулах зорилгоор Эдийн засаг, хөгжлийн яамны саналыг тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 470 дугаар тогтоолоор "Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журам" шинэчлэгдэж, хөгжлийн бодлогын баримт бичиг тус бүрийг түүний онцлогт нийцсэн аргачлалаар боловсруулах нөхцөлийг бүрдүүлсэн. Үүний дагуу "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал"-ыг үр дүнд суурилсан арга зүйд тулгуурлан боловсруулж, Эдийн засаг, хөгжлийн сайдын тушаалаар баталсан бөгөөд тус аргачлал нь урт, дунд хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт тусгагдсан тухайн жилийн хүрэх үр дүн, тэдгээрийг хэмжих шалгуур үзүүлэлт, шаардагдах хөрөнгийн хэмжээ, эх үүсвэрийг бодитой төлөвлөн, 2024 оны улсын хөгжлийн жилийн төлөвлөөний төсөлд санал тусган Эдийн засаг, хөгжлийн яаманд 01 дүгээр сарын 15-ны өдөр хүргүүлсэн. Цахим хөгжил, харилцаа холбооны яамны 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган ажиллаж байна.	100%	Үгүй	
	187		X.2.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай байгаа арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тухайн жигд хүргэхээр тооцсон зорилгот түвшинд хүргэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын холбогдох агентлагийн дарга нарт үүрэг болгов.	2023 онд тус яаманд харьяалах Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 21 арга хэмжээг unelgee.gov.mn сайт дээр сар бүр тайлагнаж байна. Мөн удаашралтай байгаа арга хэмжээний дийлэнх хувь улсын төсөвт суугдаагүй байх тул эрчимжүүлэхэд бэрхшээл учрах тохиолдол гарч байна.	100%	Үгүй	
	188		X.3.. Хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн эрхэлсэн асуудлын хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөөг гарган, хэрэгжилтийг оны эхнээс жигд ханган ажиллах, хэрэгжилт хангалтгүй төсөл, арга хэмжээг дараа жилийн төлөвлөгөөнд тусган бүрэн хэрэгжүүлж дуусгахыг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав.	Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт удаашралтай болон хангалтгүй биелэгдэж буй арга хэмжээнүүдийг яамны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хүрэх түвшинг шинэчлэн тооцон ажиллаж байна. Дээрх зорилгыг хангахын тулд "И-Монголиа" Улсын төсөвт үйлдвэрийн газрын бүтцийг шинэчлэн баталсан. Салбар дундын зохицуулалтыг хангах, бусад салбарт мэдээллийн технологийн дэвшилийг нэвтрүүлэх үүднээс салбар бүрт хамтарсан Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.	70%	Үгүй	
74	189	2023 оны 2 дугаар сарын 1-ний өдөр 6 дугаар тэмдэглэл 2023-02-01 Дугаар 2023_6	IY.2. "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэхэд чиглэсэн 2 дахь 10 жилийн цогц бодлогын баримт бичгийг уул уурхай голлосон хөгжлөөс шинжлэх ухаан, технологи, инновацид суурилсан хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон, бүх салбарт технологи, инновацийн шилжилт хийх зорилт, арга хэмжээг тусган боловсруулах Ажлын хэсгийг байгуулан ажиллаж, төслийг 2023 оны 12 дугаар сард багтаан боловсруулж, танилцуулахыг Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд Ч.Хүрэлбаатар, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх Амгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгав.	Уул уурхай голлосон хөгжлөөс шинжлэх ухаан, технологи, инновацид суурилсан хөгжлийг тэргүүлэх чиглэл болгон, бүх салбарт технологи, инновацийн шилжилт хийх зорилгын хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас салбарын төрийн бус байгууллагуудтай хамтран төрийн байгууллага төсвийн хөрөнгөөр мэдээллийн технологийн худалдан авалт хийхдээ нэн тэргүүнд дотоодын компаниудын бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч байх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор үндэсний дэд бүтцэд суурилсан худалдан авалтын шинэ систем бий болгох, улмаар дотоодын компаниудын хөгжүүлсэн програм хангамжийн бүтээгдэхүүний клауд орчинд ажиллах дэд бүтцийг бий болгосон. Энэ ажлын хүрээнд www.mindgolia.mn цахим хуудсыг хөгжүүлж, програм хангамж үйлдвэрлэгчдийн бүтээгдэхүүнийг байршуулах, байршуулсан бүтээгдэхүүнийг дотоод, гадаадад сурталчлах, төрийн байгууллагад шаардлагатай зарим програмын хангамжийг төрийн худалдан авалтын www.tender.gov.mn системийн "цахим дэлгүүр" хэсэгт байршуулж шууд худалдан авалтыг хийх нөхцөлийг бүрдсэн. Одоогийн байдлаар 100 гаруй компанийн 250 гаруй бүтээгдэхүүн байршсан байна. https://mindgolia.mn/	100%	Үгүй	
	190		XIY.1.2. Судалгааны сангийн нэгдсэн системийг ашиглах журам, хэрэглэгчийн зааварчилгааг боловсруулан баталж, мөрдүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;	Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2022 оны 12 дугаар сарын 09-ны өдрийн А/88 дугаар тушаалаар Төрийн байгууллагуудын захиалаар хийгдсэн судалгаа, зөвлөх үйлчилгээний тайлангуудыг олон нийтэд нээлттэй болгох, эргэлтэд оруулах, давхцалыг арилгах, төсвийн зарцуулалтын үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор sudalгаа.gov.mn үндэсний судалгааны нэгдсэн системийг хөгжүүлж, хэрэглээнд нэвтрүүлэх ажлын хэсгийг байгуулсан. Ажлын хэсэг Судалгааны нэгдсэн системийг хөгжүүлэн хэрэглэгч болох яам, агентлаг, аймгийн засаг дарга тамгын газрын албан хаагчдад зориулсан сургалтад төрийн байгууллагын "Нээлттэй мэдээлэл" сэдвээр танилцуулаа бэлтгэн, мэдээлэл өгч ажилласан. Ажлын хэсэг платформыг олон нийтэд танилцуулах нээлтийн арга хэмжээг 2023 оны 6 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. 2023 оны 06 сарын 30-ны өдрийн байдлаар мэдээлэл хариуцагч 74 байгууллагын 1099 судалгаа байршсан байна. Судалгааны нэгдсэн платформын хэрэглэгчийн гарын авлагыг текст болон видео хэлбэрээр платформд байршуулсан. Судалгааны платформын ашиглах, хяналт тавих журмын төслийг ЗГХЭГ боловсруулж байна. www.sudalгаа.gov.mn	100%	Үгүй	

75	191	XIV.1.3. Төрийн байгууллагууд болон зөвлөх үйлчилгээний захиалгаар хийгтэсэн судалгааны ажлын тайланг судалгааны нэгдсэн сангийн системд байршуулах, хянах, засварлах, хэрэглэгчийн саналыг хүлээн авах ажлыг холбогдох албан тушаалтанд хариуцуулж ажиллуулахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нар, төрийн болон төрийн өмчийн оролцоот хуулийн этгээд, компани, үйлдвэрийн газрын удирдлагад;	www.sudalгаа.gov.mn нэгдсэн платформд мэдээлэл хариуцагч судалгааны ажлын тайлан мэдээг үүсгэх, засварлах, хянах зэрэг хандах эрхийн зохицуулалтыг бий болгоосон холбогдох албан тушаалтан өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр хариуцан гүйцэтгэж байна.	100%	Үгүй		
	192	XIV.1.5. Судалгааны нэгдсэн системийн хөгжүүлэлт, түүний хэвийн үйл ажиллагааг ханган ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд, системийн аюулгүй байдлыг ханган ажиллахыг Тангуулын ерөнхий газар (П.Одонбаатар)-т тус тус." гэжээ.	Судалгааны нэгдсэн системийн хөгжүүлэлт, түүний хэвийн үйл ажиллагааг И-Монгол академи УТУГ хариуцан, Цахим хөгжил, харилцаа холбооны яам хяналт тавин ажиллаж байна. www.sudalгаа.gov.mn	100%	Үгүй		
75	193	IX.2. Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн батлагдсан төсвийн багцын дүнд хийсэн хөрөнгийн зохицуулалтыг Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулах зорилгоор санхүүжилтийн зохицуулалт хийх арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Монгол Улсын 2022 оны төсвийн хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн батлагдсан төсвийн багцын дүнд хийсэн хөрөнгийн зохицуулалтыг Монгол Улсын 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжид зарцуулах зорилгоор санхүүжилтийн зохицуулалт хийх арга хэмжээ авч хэрэгжүүлэн ажиллаж байна.	70%	Үгүй		
	194	2023 оны 2 дугаар сарын 8-ны өдөр 8 дугаар тэмдэглэл 2023-02-08 Дугаар 2023_8	XXV.3. "Хот, хөдөөгийн сэрэгэлтийн бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2022 оны 419 дүгээр тогтоолын 11 дэх заалтын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Батлан хамгаалахын дэд сайд, Ажлын хэсгийн дарга Б.Баярмагнайд, Ажлын хэсгийн үйл ажиллагаанд бүх талын дэмжлэг үзүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд тус тус даалгав. Хавсралт : 1 файл	1. Тус яамнаас хүн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааны журам, үйлчилгээний жагсаалт батлах тухай Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, Засгийн газрын гишүүд болон Нийслэлийн Засаг даргаас санал авч, эцсийн байдлаар нийт 790 үйлчилгээнээс лавлагаа тодорхойлолт 109, нэг шатлалт үйлчилгээ буюу үйлчилгээний хүсэлтийг хандсан цагээс нь нэмэлт шат, дамжлагагүй шийдвэрлэн хариугаа өгөх боломжтой үйлчилгээ 142, олон шатлалт үйлчилгээ буюу нийтийн мэдээллийн системээр дамжуулан үйлчилгээний хүсэлтийг хүлээн авч эрх бүхий байгууллагад шилжүүлж, шийдвэрлүүлэх 539 төрлийн үйлчилгээ, үйл ажиллагааны журам, лавлагаа тодорхойлолтын загвар болон товёёоны хамт Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт 2023 оны 02 дугаар сарын 03-ны 01/278 дугаар албан бичгээр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. 2023 оны эхний хагас жилийн байдлаар төрийн нийт 790 үйлчилгээнээс 440 үйлчилгээг төрийн үйлчилгээний цэг, киоск машинаар хүн, хуулийн этгээдэд үзүүлж байна.	100%	Үгүй	
	195	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	XXXV.11.2. "Цахим эрүүл мэнд" төслийг шинэчлэн боловсруулж, цахим шилжилтийг үргэлжлүүлэх талаар холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг нарт даалгав; 3."Цахим эрүүл мэнд" төслийг хэрэгжүүлэх явцад гарсан хууль бус үйлдэл, үйл ажиллагааг Авлигатай тэмцэх газарт шилжүүлж шалгуулах, уг хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд төрийн ашиг сонирхлыг хамгаалах этгээдээр прокурорын байгууллагыг оролцуулах арга хэмжээ авахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Хууль зүй дотоод хэргийн сайд Х.Нямбаатар нарт даалгав.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглагдаж буй программ хангамж, мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэн, эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх үүрэг бүхий хамгарсан Ажлын хэсгийг /Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Эрүүл мэндийн сайдын/ 2023 оны 03 сарын 31-ний өдөр байгуулсан.Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй программ хангамжууд хооронд нэгдсэн стандартаар мэдээлэл солилцох загвар, техникийн шаардлага бүхий мэдээлэл солилцооны архитектур, шийдлийг төслөөр боловсруулсан.	100%	Үгүй	
76	196	2023 оны 2 дугаар сарын 20-ны өдөр 9 дүгээр тэмдэглэл 2023-02-20 Дугаар 2023_9	III.5. Авлигатай тэмцэх жилийн хүрээнд авлигыг таслан зогсоох, хүнд суртлыг арилгах чиглэлээр хариуцсан салбар бүрдээ тодорхой арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав. www.shilen.gov.mn Мөн 2023 оны 03 дугаар сарын 21-ны өдөр Авлигатай тэмцэх газрын урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх хэлтсээс зохион байгуулсан авлигын эсрэг хууль тогтоомж, авлига, ашиг сонирхлын зөрчил, авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалтад Цахим хөгжил, харилцаа холбооны яамны болон харьяа байгууллагуудын албан хаагчид хамрагдсан. Хавсралт : 2 файл	Авлигатай тэмцэх жилийн хүрээнд ЦХХХ-ны сайд Н.Учрал Шил ажиллагааны ажлын хэсгийг ахлан Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар үйл ажиллагаа явуулж байгаа нийт 24 тусгай сан байгаа бөгөөд тэдгээрийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг www.shilen.gov.mn-д ил тод байршуулсан. Мөн ЦХХХ-ны дэд сайд Шүгэл ажиллагааны ажлын хэсэгт томилогдон үр дүнтэй ажиллаж байна.	100%	Үгүй	
	197	Тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа шинжилгээний хэлтсээс Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт техник технологид суурилсан төрөл бүрийн үйлчилгээнүүдийн талаарх судалгаа, Эрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааг хийсэн ба энэ талаарх мэдээллийг байгууллагын веб сайт хуудасны мэдээ цэсний, судалгаа дэд цэсэд байршуулсан. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудаст Засгийн газрын бодлого шийдвэр, нийгмийн хүлээлтэй холбоотой олон мэдээ мэдээллийг мэдээ цэсэнд байршуулан ажиллаж байна. Линк: https://mddc.gov.mn/mn/%d1%81%d1%83%d0%b4%d0%bb%d0%b3%d0%b0%d0%b0/	Тус яамны Бодлого төлөвлөлтийн газрын Судалгаа шинжилгээний хэлтсээс Мэдээлэл, харилцаа холбооны дэвшилтэт техник технологид суурилсан төрөл бүрийн үйлчилгээнүүдийн талаарх судалгаа, Эрхийн мэдээлэл, харилцаа холбоо, технологийн хэрэглээ, хүртээмжийн судалгааг хийсэн ба энэ талаарх мэдээллийг байгууллагын веб сайт хуудасны мэдээ цэсний, судалгаа дэд цэсэд байршуулсан. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамны цахим хуудаст Засгийн газрын бодлого шийдвэр, нийгмийн хүлээлтэй холбоотой олон мэдээ мэдээллийг мэдээ цэсэнд байршуулан ажиллаж байна.	100%	Үгүй		

	198		<p>IV.2.2. "Дэлхийн үүрэн холбооны конгресс 2024" арга хэмжээнд оролцох нэгдсэн зохион байгуулалтын бэлтгэл ажлыг хангаж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Харилцаа холбооны зохицуулах хороо (Г.Чинзориг), Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл), "Мэдээлэл холбооны сүлжээ" ХХК (Б.Мөнхбат) нарт даалгав.</p>	<p>Дэлхийн цахилгаан холбооны салбарын хамгийн том олон улсын экспо "Дэлхийн үүрэн холбооны конгресс" (Mobile World Congress) 2023 оны 2 дугаар сарын 27-ны өдрөөс 3 дугаар сарын 1-ний өдрүүдэд Испанийн Вант Улсын, Барселона хотноо зохион байгуулагдсан билээ. Уг арга хэмжээнд Монгол улсаас оролцсон аж ахуй нэгж, байгууллагууд, үндэсний программ хангамж үйлдвэрлэгч компаниудад дэмжлэг үзүүлж, Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын санаачилгаар Монгол Улсаас нэгдсэн зохион байгуулалттайгаар анх удаа Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарын байгууллагуудын төлөөлүүд хамтран оролцов.</p>	100%	Үгүй	
77	199	<p>2023 оны 3 дугаар сарын 07-ний өдөр 11 дүгээр тэмдэглэл 2023-03-07 Дугаар 2023_11</p>	<p>XII.5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон салбарын бодлого, стратегийн төлөвлөгөө, Жендэрийн үндэсний хорооны 2023 оны ээлжит хуралдаанаас гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахыг Засгийн газрын гишүүд, яамдын жендэрийн салбар зөвлөл, орон нутгийн салбар хорооны дарга, Жендэрийн үндэсний хорооны гишүүдэд тус тус даалгав.</p>	<p>"1. Салбарын бодлого, төлөвлөлт, үйл ажиллагаа, хэрэгжилтийн үнэлгээнд жендэрийн үзэл баримтлалыг нэвтрүүлэх, бүх нийтийн цахим ур чадварыг сайжруулах, салбарын стратегийг жендэрийн арга зүйгээр дэмжин ажиллах зорилгоор Цахим хөгжил, харилцаа холбооны салбарт баримтлах Жендэрийн стратеги, үйл ажиллагааны чиглэл (2023-2026)-ийг тус яамны сайдын 2023 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн А/05 тушаалаар батлуулав.</p> <p>2. Монгол Улсын Ерөнхий Сайдын 99 дүгээр захирамжаар баталсан эрэгтэй эмэгтэй хүний дундаж наслалтын зөрүүг багасгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг маягтын дагуу гаргаж 2023 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 03/133 дугаартай албан бичгээр Жендэрийн үндэсний хороонд хүргүүлэв.</p> <p>3. ЖЭТБХангах тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд ХХТМ-ийн салбарын байгууллагуудаас 2022 онд хэрэгжүүлсэн үйл ажиллагааны тайланг УСХ-ны даргын А/49 дүгээр тушаалаар баталсан маягт, зааврын дагуу боловсруулан 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 01/61 дугаартай албан бичгээр ЖУХ-нд хүргүүлэв.</p> <p>4. ХХМТ-ийн жендэрийн салбар зөвлөлийн 2023 оны төлөвлөгөөг 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр Төрийн нарийн бичгийн дарга батлав.</p>	100%	Үгүй	
	200		<p>XII.2.3. Эрүүл мэндийн салбарын цахим системийн хэвийн найдвартай үйл ажиллагааг хангах чиглэлээр зохих арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт;</p>	<p>"1. Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 2 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 08 дугаар тэмдэглэлийн 2 дахь заалтаар үүрэг болгосны дагуу "Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд ашиглагдаж буй программ хангамж, мэдээллийн сан хооронд мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэн, эрүүл мэндийн цахим шилжилтийг эрчимжүүлэх" үүрэг бүхий хамтарсан ажлын хэсэг (Цахим хөгжил, харилцаа холбооны сайд, Эрүүл мэндийн сайдын 2023.03.31, А/27, А/114) байгуулсан. Ажлын хэсгийн хэсгийн удирдамжийн дагуу мэдээлэл солилцооны HL7/FHIR олон улсын стандарт, SNOMED-CT, LOINC код, нэр томъёоны толь зэргийг судалж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд ашиглагдаж буй программ хангамжууд хооронд нэгдсэн стандартаар мэдээлэл солилцох загар, техникийн шаардлага бүхий мэдээлэл солилцооны системийн архитектур, шийдлийн төслийг боловсруулсан.</p> <p>2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээний "Карте" системийг төрийн үйлчилгээний системд холбогдох хүсэлтийн дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэгч байгууллага, программ хангамж хөгжүүлэгч, "И-Монгол" УТГГ зэрэг байгууллагуудын хоорондын уялдааг хангаж ажилласны үр дүнд "Карте" системийг хэрэглэгч 14 эмнэлэг төрийн үйлчилгээний "E-Mongolia" системд холбогдож, үйлчлүүлэгчид шинжилгээний хариу, эмнэлгийн цаг захиалах үйлчилгээг цахимар авах нөхцөл бүрдсэн.</p>	100%	Үгүй	
	201		<p>2. Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг шинэчилж, хууль тогтоомж, хөгжлийн бодлогын баримт бичиг, тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийг тайлагнах, үнэлэх үйл ажиллагааг боловсронгуй болгох, олон улсын жишигт нийцүүлэх, цахимжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар (Б.Баасандорж), Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав". гэжээ.</p>	<p>Бүртгэл, хяналтын удирдлагын нэгдсэн цахим систем "unelgee.gov.mn"-тэй холбоотой төслийн гэрээ, гэрээний гүйцэтгэлийн тайлан, гэрээ дүгнэсэн акт, систем хүлээж авснаас хойш хийгдсэн нэмэлт ажлууд, системийн аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитын дүгнэлт, зөвлөмж, түүний хэрэгжилтийн тайлан, систем ашиглалтын гарын авлага, ашиглах заавар, патентын болон зохиогчийн эрхийн гэрчилгээ (эх кодын хамт), систем администраторын жагсаалт, хандах эрхийн түвшин, системийн үйл ажиллагаатай холбогдох бусад материал, мэдээллийг ирүүлэх талаар 07 дугаар сарын 03-ний өдрийн 03/1412 дугаар албан бичгээр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн. Мөн Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас яамдын Төрийн нарийн бичгийн бүрэлдэхүүнтэй "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг шинэчилэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж эхний ажлын хэсгийн хуралдаанаар хариуцан гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг гаргаж 8 дугаар сарын 15-ны өдрөөс өмнө хийж гүйцэтгэхээр ажиллаж байна.</p>	30%	Үгүй	
			<p>Хэрэгжилт удааширсан шалтгаан: Зохион байгуулалтаас</p>				
			<p>Хавсралт : 1 файл</p>				

78	202	2023 оны 3 дугаар сарын 29-ний өдөр 14 дүгээр тэмдэглэл 2023-03-29 Дугаар 2023_14	<p>XVIII.7.3. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:</p> <p>3. Олон улсын байгууллагын техник тусалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагчдыг төгсмөгц, ажлын байранд нь эргүүлэн томилж ажиллуулах арга хэмжээ авч байхыг яамдын Төрийн нарийн бичгийн дарга, агентлагийн дарга нарт;</p>	<p>Албан хаагчдын мэдлэг боловсролыг дээшлүүлэх талаар бүх боломж нөхцөлийг судлан, дэмжин ажиллаж байна. Одоогоор олон улсын байгууллагын техник тусалцааны төслийн хүрээнд гадаад улсад магистр, доктор болон ахисан түвшний сургалтад хамрагдсан төрийн албан хаагч байхгүй байна. Цаашид төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжийн хүрээнд магистр, докторын ахисан түвшний сургалтад хамрагдаж төгссөн төрийн албан хаагчдыг буцааж томилох, ажлын байраар хангах арга хэмжээг авч ажиллах болно.</p>	X.Б	Үгүй	
	203		<p>XVIII.7.4. Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагын ажилтнуудтай 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр хийсэн уулзалтын талаар Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд даалгав:</p> <p>Олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд төрийн албан хаагчийг мэргэшүүлэх зорилгоор гадаад улсад туршлага судлах сургалт, аялалд хамруулах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд;</p>	<p>Тус яамны албан хаагчдыг албан тушаалын тодорхойлолтод заасан үйл ажиллагааны чиглэл, гүйцэтгэж байгаа ажил үүргийн дагуу олон улсын байгууллагын санхүүжилтээр хэрэгжүүлэх төслийн хүрээнд гадаад улсад туршлага судлах сургалтад тогтмол хамруулж байна.</p>	100%	Үгүй	
79	204		<p>X.2.2. Шилдэг оролцогчоор шалгарсан албан хаагчдыг үндсэн цалинг 3 сараар, 20 хүртэл хувиар нэмж урамшуулах арга хэмжээ авахыг холбогдох яамдын Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав.</p>	<p>Шилдэг оролцогчоор шалгарсан тус яамны Бодлого, төлөвлөлийн газрын ахлах шинэчэн Э.Бямбасүрэнд Төрийн нарийн бичгийн даргын 2023 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн Б/77 дугаар тушаалаар урамшуулал олгосон.</p> <p>Хавсралт : 1 файл</p>	100%	Үгүй	
	205	2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр 15 дугаар тэмдэглэл 2023-04-05 Дугаар 2023_15	<p>XI.8.1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн явц болон төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хуулийн хэрэгжилтийг хангах, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийг эрчимжүүлэх, төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системийн ашиглалтыг бүх түвшинд сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан албан тушаалтанд даалгав:</p> <p>Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх үйл ажиллагааг "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-д заасны дагуу Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-ээр хэрэгжүүлэх, төсвийн хэмжээний хүрээнд энэ чиглэлийн ижил төрлийн цахим систем үүсгэхгүй байхыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт;</p>	<p>Хөрөнгийн зардал Хөрөнгийн зардалд 11 төсөл арга хэмжээнд 6.34 тэрбум төгрөгийн төсөв батлагдсан. Үүнээс 4 төсөл арга хэмжээ он дамжин хэрэгжиж, 7 төсөл арга хэмжээ шинээр хэрэгжсэн. Онцлох төсөл арга хэмжээний хувьд Сумдад төрийн цахим үйлчилгээг нэвтрүүлэх "Хур" систем Улсын хэмжээнд 2019-2022 онд 22.2 тэрбум төгрөгөөр 27 багц төсөл, арга хэмжээ амжилттай хэрэгжиж дууссан. Дээрх төслийн хүрээнд 21 аймагт нөөц тэжээлийн үүсгүүр, цахим үйлчилгээний тоног төхөөрөмж нийлүүлсэн. Мөн 75 цагт харилцаа холбооны цамаж угсралт, суурилуулалтын ажил хийгдэж, 18 аймгийн 25 суманд шинэ барилга, 179 суманд их засварын ажил хийгдэж бүрэн дууссан. Нийт батлагдсан төсвөөс Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 393 дугаар "Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын дагуу Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөвт Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд зохицуулалт хийж 6.34 тэрбум төгрөгийн төсвөөс буурч 5.7 тэрбум төгрөг болж төлөвлөгөөнд өөрчлөлт орсон. Тайлант онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд нийт 5,71 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, 99 хувийн гүйцэтгэлтэй тайлагнасан. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-д Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төслүүдийн гэрээний мэдээллийг шинэчлэн оруулсан. Мөн 2023 онд "Мэдээлэл холбооны Дархан дэд төв (Дархан-Уул, Дархан сум, 1, 2, 3 дугаар баг)" төслийн 1,627,312,114 төгрөгийн санхүүжилтийн материалыг бүрдүүлэн Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем (PIMIS)-д нэгтгэн оруулсан.</p>	100%	Үгүй	

80	206	2023 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн 16 дугаар тэмдэглэл 2023-04-12 Дугаар 2023_16	<p>XIX.1. Нийслэлийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд зориулан бэлтгэсэн нөөцийн махыг худалдан борлуулах цагийг нэмэгдүүлэх, төв цэнгэлдэх хүрээлэнд худалдаалах цэг гаргах, аймаг, орон нутгаас мөх ачсан тээврийн хэрэгслийг нийслэл хот руу саадгүй нэвтрүүлэх, нөөцийн махны чанарын асуудлаар мэдээлэл хийх зэрэг арга хэмжээ авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Х.Болорчулуун нарт, уг ажилд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгаланд даалгав.</p> <p>Төрийн болон төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн төлөөлөлтэй хийх уулзалтын үеэр "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, Засгийн газрын "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг сурталчлан таниулж, хэрэгжилтийн явцын талаар мэдээлж ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.</p> <p>Төрийн ордны хашааны засварын асуудлаар иргэд, олон нийтээс ирүүлж буй шүүмжлэлийг харгалзан үзэх, засварын ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан нарт даалгав.</p> <p>Хөтөлийн цемент шохойн үйлдвэрийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт, үйлдвэрийн захирлын асуудлаарх ажилчдын шаардлагыг нягтлан шалгаж, дүнг танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т</p>	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.	Х.Б	Тийм	Цахим хөгжил, харилцаа холбооны яамны үйл ажиллагаа, чиг үүрэгт хамаарахгүй байх тул хяналтаас хасуулах саналтай байна.
	207		<p>XX.7. Эмнэлэгт өвчтөн илгээх 13А маягтыг цахимжуулах талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав.</p> <p>Үүнтэй холбогдуулан Эмнэлэгт өвчтөн илгээх АМ-13А, АМ-13Б, АМ-13В маягтыг цахим хэлбэрээр олгох нөхцөлийг бүрдүүлж, эрүүл мэндийн салбарын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэн ажиллахыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт даалгав.</p>	Эрүүл мэндийн даатгалын цахим систем ашиглан 13А маягтыг цахимаар үүсгэх, шигжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэхээр Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар, И-Монгол академи" Улсын төсөвт үйлдвэрийн газартай хамтран ажиллаж Үндсэн системд холбогдох сервисүүдийг гаргаж өгөх, шаардлагатай мэдээллээр хангах, сервисийн ажиллагааг бодит орчинд төстлөх, төстийн өгөгдлөөр хангах ажлууд хийгдсэн. Эрүүл мэндийн даатгалын "health.gov.mn" системд түшиглэн эрүүл мэндийн үйлчилгээнд ашиглагдаж буй 4 төрлийн мэдээллийн систем хооронд 13А маягтын мэдээллийг цахимаар бүртгэх, солилцох нэмэлт хөгжүүлэлтийг хийж, анхан шатны 530, лавлагаа шатлалын 334, нийт 864 эмнэлэг цахимаар хүлээн авах, илгээх боломж бүрдсэн. 13А маягтыг иргэнд хүргэхэд шаардлагатай хөгжүүлэлтийг хийж төрийн цахим үйлчилгээний "И-Монголиа" системд нэгтгэж, "Үйлчилгээ" цэсийн "Эрүүл мэнд" ангилалд 13А цахим маягтыг байршуулсан. 13А маягтад иргэний шинжилгээний мэдээллийг давхар илгээх, насанд хүрээгүй хүүхдийн маягтыг түүнийг төлөөлөх эрх бүхий этгээд нь харах, татан авах нөхцөлийг тус тус бүрдүүлсэн. 13А цахим лавлагааг Нийслэл болон орон нутгийн эрүүл мэндийн 545 байгууллагаас төрийн үйлчилгээний нэгдсэн "E-Mongolia" системд 16,871 үүсгэсэн байна.	100%	Үгүй	
81	208		XIX.2.3. Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмжийг биелүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд болон бүх шатны Засаг дарга нарт тус тус үүрэг болгов	Хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн зөрчлийг арилгуулахаар Хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээс гаргасан шаардлага, зөвлөмж ирээгүй болно.	100%	Үгүй	
	209	2023 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2023-04-19 Дугаар 2023_17	XIX.2.5. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэх асуудлыг судлан холбогдох саналаа боловсруулж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалан, Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт тус тус даалгав	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг боловсруулах ажиллагаа Хууль зүй, дотоод хэргийн яаманд хийгдэж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг Хууль зүйн үндэсний хүрээлэн хийж байна. Уг үнэлгээг үндэслэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцүүлэх асуудлыг судлан холбогдох саналыг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулахаар ажиллаж байна.	30%	Үгүй	
	210		XIX.1.4. "Шинэ тойрог зам" төслийн урд хэсэг, Туулын авто зам болон Туулын авто замыг Нисэхийн хурдны авто замтай холбох (Туулын авто замаас Нүхтийн авто зам хүртэл) авто замын төслийн техник, эдийн засгийн үндэслэл, барилгын ажлын нэрийг авчирсан зураг төслийг баталгаажуулахад шаардлагатай холбогдох техникийн нөхцөлийг шуурхай олгож ажиллахыг Эрчим хүчний сайд Б.Чойжилсүрэн, Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт, Барилга, хот байгуулалтын сайд Ц.Даваасүрэн, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар нарт;	Зам, тээврийн хөгжлийн яам "Шинэ тойрог зам" барих төслийн гүйцэтгэгч сонгон шалгаруулж, гүйцэтгэгч харилцаа холбооны техникийн нөхцөл авах хүсэлт ирүүлсний дараа уг техникийн нөхцөлийг олгох асуудлыг шийдвэрлэнэ.	Х.Б	Үгүй	

82	211		ХҮИИ.3.2. Шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэхэд оролцох албан хаагчийг томилон ажиллуулахыг холбогдох Засгийн газрын гишүүдэд даалгав.	Тус яамны төлөвлөгөө, тайлан хариуцсан албан хаагч шаардлагатай мэдээлэл, тайланг бэлтгэн тухай бүрт нь хүргүүлэн ажиллаж байна.	70%	Үгүй	
	212	2023 оны 5 дугаар сарын 03-ны өдөр 19 дүгээр тэмдэглэл 2023-05-03 Дугаар 2023_19	ХҮИИ.8.1. Монгол Улсаас хилийн чанадад суугаа дипломат төлөөлөгчийн газар, байнгын ажиллагаатай хилийн боомтод төрийн үйлчилгээний цэгийг нээх ажлыг үе шаттайгаар зохион байгуулахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд;	"Төрийн үйлчилгээний "ХУРДАН" цэгийг хилийн чанадад БНСУ-ын Сөүл хот дахь консулын байр, Хөдөлмөр нийгмийн хамгаалалын газар, Бусан хот дахь консулын газар, Австри Улсын нийслэл Вена хот дахь элчин сайдын яам, Энэтхэг Улсын Ерөнхий консулын газар, Сингапур Улсын Консулын газар, Япон Улсын Токио хот дахь Элчин сайдын яам, Осака хот дахь Ерөнхий консулын газар зэрэг 5 улсын нийт 8 байршид салбарын үйл ажиллагааг эхлүүлсэн. " Хавсралт : 1 файл	100%	Үгүй	
	213		ХҮИИ.9. Нэмэгдсэн өртгийн албан татвар, түүний хэрэгжилт, тулгамдаж байгаа асуудлын талаар Сангийн сайд Б.Жавхлан Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан эрхэлсэн хүрээний асуудалд хамаарах бараа, ажил, үйлчилгээнд ногдох нэмэгдсэн өртгийн албан татвартай холбоотой хууль тогтоомжийн төслийг Сангийн сайдтай урьдчилан зөвшилцсөний үндсэн дээр боловсруулж байхыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Нийт 20 байгууллагыг "e-barimt" системтэй холбосон ба 2023 оны 5 дугаар сарын байдлаар нийт 37,927,857 баримтыг утасны дугаараар бүртгэсэн. Мөн энэ оны 2 дугаар улиралд багтаан "СУ" үйлчилгээний төвийг тус системтэй холбохоор, 106 байгууллагын 61,128 хэрэглэгчийн кассын системийг шинэчилж 3.0 хувилбарыг нэвтрүүлэхээр ажиллаж байна.	70%	Үгүй	
3Г-ын албан даалгавар							
83	214	Цахим шилжилтийг эрчимжүүлэх тухай 2022-07-04 Дугаар 2022_3	2. Энэ албан даалгаврын 1-д заасан төлөвлөгөөнд тусгах нийтийн мэдээллийн дэд бүтцэд хамаарах төсөл, хөтөлбөр, арга хэмжээг төлөвлөхдөө Цахим хөгжил, харилцаа холбооны яамны санал, зөвлөмжийг заавал авч байхыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.	"Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт "Мэдээлэл хариуцагч нийтийн мэдээллийн систем үүсгэхийн өмнө үйл ажиллагаанд зөвлөмж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу дараах 4 мэдээлэл хариуцагчаас, 6 системд зөвлөмж дүгнэлт гаргуулахаар холбогдох мэдээллээ ирүүлсэнийг судлан, зөвлөмжийн төслийг боловсруулж хүргүүлсэн. Үүнд: - Соёлын яамны "G.L.A.M" систем болон уран бүтээл, урын сангийн бүртгэлийн цахим нэгдсэн сан, Соёлын өвийн бүртгэлийн нэгдсэн цахим сан, Номын сангийн программ"; 2023 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн 03/849 дугаар албан бичиг, - "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын "Цахим системүүдийн интеграци хийх ажил"; 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 03/775 дугаар албан бичиг, - Архангай аймаг "Аймгийн нутгийн захиргааны үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэд, олон нийтийн оролцоо, мэдээллийн хүртээмжийг сайжруулах зорилготой их бүрэн цахим платформ"; 2023 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн 03/774 дугаар албан бичиг, - Ашигт малтмал, газрын тосны газрын "Уул уурхайн кадастрын компьютержсан систем УУККС"-ийн өргөтгөл сайжруулалтын II шатны ажлын зөвлөмж, дүгнэлтийг боловсруулж, 2023 оны 05 сарын 31-ний өдрийн 06/1184 дугаар албан бичгээр хүргүүлсэн."	100%	Үгүй	
84	215	Цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх тухай 2022-07-05 Дугаар 2022_5	1. Цахим шилжилт, төрийн бүтээмж, залуучуудын үзэл бодол, нийгмийн оролцоо, замын тэмдэглэгээ, гэр хорооллын хөгжил, цахим гэмт хэрэг зэрэг цаг үеийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх чиглэлээр дараахь арга хэмжээг 2022 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн дотор авахыг Засгийн газрын дор дурдсан гишүүд, холбогдох албан тушаалтанд тус тус ДААЛГАСУГАЙ: 1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын үүрэг хариуцагч Л.Энх-Амгаланд: 1.1. Төрийн байгууллагуудын нэгдсэн цахим шуудангийн системийг ашиглалтад оруулж, төрийн албан хаагчдад нэвтрүүлэх; 1.2. Төрийн байгууллагуудын нэгдсэн программ хангамжаар хангах, байгууллагын үйл ажиллагааны хэрэгжилтийг янах нэгдсэн систем бий болгох судалгаа хийж, саналаа танилцуулах;	1.1. Төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгож, нээлттэй, ил тод, шуурхай байлгах зорилгоор төр, иргэний холбосон мэдээлэл дамжуулах цахим суваг болох "ҮНДЭСНИЙ ЦАХИМ ШУУДАН"-ийн систем /www.mail.mongolia.mn/-ийг нэвтрүүлж, 1.6 сая хэрэглэгчид мэдэгдэл хүргэх боломжийг бүрдүүлсэн. Үндэсний цахим шуудангийн системд төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллага (193 хаг)-ын албаны цахим шууданг холбож, өргөдөл, гомдлыг хүлээн авч, хариу хүргүүлэх боломжийг бүрдүүлсэн. 1.2. Төрийн байгууллага мэдээллийн технологийн худалдан авалт хийхдээ нэн тэргүүнд дотоодын компаниудын бүтээсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авч байх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх, үндэсний дэд бүтцэд суурилсан худалдан авалтын систем бий болгох, түүнд байрших программ хангамжийн бүтээгдэхүүнд тавигдах шаардлагын талаар санал боловсруулж "Программ хангамжийн их дэлгүүр www.mindgolia.mn" цахим хуудсыг хөгжүүлэн, ашиглалтад оруулсанаар тус цахим системд 2023 оны 06 дугаар сарын байдлаар 29 ангилалд 378 хуулийн этгээдийн 385 бүтээгдэхүүн байршаад байна. Төрийн худалдан авах ажиллагааны газартай хамтран www.mindgolia.mn-д байршуулсан бараа, бүтээгдэхүүнээс тодорхой шалгуурын дагуу сонгогдсон байгууллагын бүтээгдэхүүн, үйлчилгээг Сангийн сайдын 2017 оны 234 дүгээр тушаалаар батлагдсан "Ерөнхий гэрээ"-ний журамд зааснаар "www.tender.gov.mn"-д нийлүүлж, төрийн байгууллага шууд худалдан авах боломжийг судалж эхний ээлжид ERP системүүдийг цахим дэлгүүрт оруулах ажил хийгдэж байна.	100%	Үгүй	
	216		7. Албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, шаардлагатай бол Ажлын хэсэг байгуулж ажиллах, биелэлтийг Төрийн бүтээмжийн болон Хот хөдөөгийн хөгжлийн тэнцвэрийг хангах, төвлөрлийг сааруулах, авто замын түгжрэлийг бууруулах үндэсний хороодын хуралдааны тус тус хэлэлцүүлэх арга хэмжээ авахыг Үндэсний хороо (Орлогч дарга Л.Энх-Амгалан, Л.Халтар)-нд даалгасугай.	Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооноос ирүүлсэн түгжрэлийг бууруулах ойрын болон дунд хугацаанд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөнд тусгах санал, Нийслэл Улаанбаатар хотын замын хөдөлгөөний түгжрэл, түүний сөрөг нөлөөллийг бууруулах хуулийн төсөл, зөвлөмжийн төсөлд санал боловсруулан 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 01/2017 дугаар албан бичиг, 2022 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 01/2232 дугаар албан бичгээр тус тус хүргүүлсэн. Хавсралт : 2 файл	100%	Үгүй	

85	217	Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаар авах арга хэмжээний тухай 2022-11-16 Дугаар 2022_16	1. Сангийн сайд Б.Жавхлан, Эдийн засаг, хөгжлийн сайд Ц.Хүрэлбаатар, Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал нарт; 1.Гаалийн хяналтын талбай болон албан ажлын өрөөнүүдийг камержуулах арга хэмжээг бүрэн дуусгах; 2.Гаалийн байгууллагын үйлчилгээг цахимжуулж, хилийн боомт, гаалийн хяналтын бүсийн үйл ажиллагаанд хүний оролцоог багасгах, барааг урьдчилан мэдүүлэх үйл ажиллагааг хялбаршуулах чиглэлээр тодорхой арга хэмжээ авах; 3.Гааль, татварын автомат бүрдүүлэлтийн систем бий болгох арга хэмжээг эрчимжүүлэх;	2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Авилгатай тэмцэх газар, Гаалийн ерөнхий газар хамтран зохион байгуулсан "Экспорт, импортын зөвшөөрөл олгох, хянах чиг үүрэг бүхий төрийн байгууллагын мэдээллийг цахимжуулах гарц, шийдэл" хэлэлцүүлэгт "Цахим шигжилт, салбар хоорондын уялдааг хангах арга зам" сэдвээр илтгэл хэлэлцүүлж оролцсон. Гаалийн ерөнхий газраас санал, зөвлөмж боловсруулсны дараа Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 29.1-д заасны дагуу Цахим хөгжил, харилцаа холбооны яамны зүгээс зөвлөмж, дүгнэлт өгөх, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах боломж бүрдэнэ. Хавсралт : 2 файл	70%	Үгүй	
86	218	"Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01	1.4. Засгийн газрын тусгай сангийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг холбогдох шийдвэрийн хамт хүргүүлэхийг Засгийн газрын холбогдох гишүүдэд;	Монгол Улсын Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар нийт 24 тусгай сан үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд тэдгээрийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэл, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний 2008 оноос хойших мэдээллийг ил тод байршуулах ажлын хүрээнд Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан, Хөдөө аж ахуйг дэмжих сан, Улсын авто замын санг, Соёл, урлагийг дэмжих сан, Кино урлагийг дэмжих сан, Гэмт хэргийн хохилогчид нөхөн төлбөр олгох сан, Боловсролын зээлийн сан, Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сан, Шинжлэх ухаан, технологийн сан, Байгаль орчин, уур амьсгалын сан, Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд тусласан сан, Нийгмийн халамжийн сан, Нийгмийн даатгалын сан, Хүүхдийн төлөө сан, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Ирээдүйн өв сан, Төсвийн тогтворжуулалтын сан, Эрүүл мэндийн даатгалын сан, Эрүүл мэндийг дэмжих сан, Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан, Спортыг дэмжих сангийн гэрээний мэдээлэл, зээлийн мэдээлэл, зарцуулалтын талаарх мэдээлэл, зээлийн үлдэгдлийн талаарх мэдээлэл, нөхөн төлбөрийн мэдээллийг жагсаалтын хамт ил тод болгосон. www.shilen.gov.mn	100%	Үгүй	
	219		1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Шил ажиллагааны хүрээнд яам, агентлаг болон аймаг, нийслэлийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 120 гаруй төрийн болон орон нутгийн өмчит, өмчийн оролцоотой мэдээлэл хариуцагч байгууллагатай холбогдож, info@shilen.gov.mn цахим шуудангаар 400 гаруй багц мэдээллийг хүлээн авч, shilen.gov.mn системд байршуулсан. Боловсролын зээлийн сангийн 2007-2023 оны хооронд нийт 1,605 суралцагчид гадаадын зээл, тэтгэлийн чиглэлээр олгосон 269.9 тэрбум төгрөгийн санхүүжилт, түүнээс 259.7 тэрбум төгрөгийн зээлийн мэдээллийг жагсаалтын хамт shilen.gov.mn системд байршуулсан. Шил ажиллагааны "shilen.gov.mn" системийг 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдөр ашиглалтад оруулснаас хойш 2023 оны 5 сарын 30-ны өдрийн хооронд нийт 729,935 мэдээллийг байршуулж, нийт 2,072,501 удаагийн хандалт авсан байна. www.shilen.gov.mn	100%	Үгүй	
87	220	"Шил" ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01	2. Албан даалгаврын 1-д заасан мэдээллийг нэгтгэн "Шилэн индекс" гаргаж, дүнг Засгийн газрын хуралдаанд тухай бүр танилцуулж ажиллахыг Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учралд даалгасугай.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу нээлттэй мэдээллийг 98 шалгуур үзүүлэлтээр 7 хоног бүр үнэлж "Шилэн Индекс"-ийг зарласан. Үүнд: Төрийн захиргааны төв байгууллагын хувьд дундаж үзүүлэлт 95%, төрийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт 78%, нутгийн захиргааны байгууллагуудын хувьд дундаж үзүүлэлт 67%, нийслэлийн 9 дүүргийн хувьд дундаж үзүүлэлт 70%-тай тус тус үнэлэгдсэн. www.shilen.gov.mn	100%	Үгүй	

ЦАХИМ ХӨГЖИЛ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ЯАМАНД ХАМААРАХ “ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ”-ИЙН БИЕЛЭЛТИЙН ТАЛААР

2023 оны 07 дугаар сарын 06-ны өдөр

Улаанбаатар хот

НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО, ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ

Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго нь Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтэд 2023 оны эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үйл ажиллагааны гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, дүгнэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтоохдоо дээрх журмын “Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй” болон үр дүн, нотлох баримтад тулгуурлах зарчмыг баримталлаа.

ХОЁР. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах Монгол Улсын 7 хуулийн 72 заалт, Улсын Их хурлын 7 тогтоолын 14 заалт, Улсын Их хурлын Байнгын хорооны 6 тогтоолын 32 заалт, Ерөнхийлөгчийн 6 зарлигийн 8 заалт, Засгийн газрын 23 тогтоолын 27 заалт, Засгийн газрын хуралдааны 29 тэмдэглэлийн 56 заалт, Засгийн газрын 4 албан даалгаврын 7 заалт, Ерөнхий сайдын 3 захирамжийн 3 заалт, Үндэсний аюулгүй байдлын 1 зөвлөмжийн 1 заалт нийт 220 заалт бүхий хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт байгаагаас 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд дараах үр дүн гарлаа. Үүнд:

1. Бүрэн хэрэгжсэн буюу 100%-ийн биелэлттэй арга хэмжээ -148
 2. Хэрэгжих шатандаа буюу 70%-ийн биелэлттэй арга хэмжээ – 36
 3. Хэрэгжилт хангалтгүй буюу 30%-ийн биелэлттэй арга хэмжээ – 15
 4. Хэрэгжилт байхгүй ажил - 0
 5. Хугацаа болоогүй буюу үнэлэх боломжгүй – 21 арга хэмжээ байна.
- Хэрэгжилтийн дундаж: 89.3% хувьтай дүгнэгдлээ.

ГУРАВ. ДҮГНЭЛТ

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2023 оны 07 дугаар сарын 05-ны өдрийн байдлаар нийт 220 заалтад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ үр дүнд суурилсан, нотолгоонд тулгуурласан байх зарчмыг баримталлаа.

Тус яаманд хамаарах ажлуудаас Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийн биелэлт амжилттай буюу 100 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Тодруулбал, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хүрээнд тус яам өөрт хамаарах 68 төрлийн мэдээллийг ил тод байршуулсан. Үүний зэрэгцээ Монгол Улсын Засгийн газар 2023 оныг “Авлигатай тэмцэх жил” болгон

зарлаж, авлигатай тэмцэх таван Ш буюу Шүгэл, Шүүр, Шувуу, Шилжүүлэн авах болон Шил ажиллагааг хэрэгжүүлсэн. Иргэдийн мэдээлэл хайх, мэдээлэл хүлээн авах эрхийг хангах, “Шил ажиллагаа”-ны хүрээнд Цахим хөгжил, харилцаа холбооны яам тэргүүлэн ажиллаж байна.

Ингэснээр төрийн байгууллагууд мэдээллээ нээлттэй, ил болгох үйл явц эрчимжиж, Shilen.gov.mn сайтад нийтэлж эхэлсэн бөгөөд шил ажиллагааны гол зорилго бол төрд хэн, хаана, хэзээ, юу хийж байгааг шууд хянах боломжийг технологийн шийдлийн тусламжтайгаар иргэнд олгож байгаа явдал юм. Уг платформыг 2023 оны гуравдугаар сарын 27-ны өдөр “Шилэн” ажиллагааны хүрээнд нээсэн бөгөөд “Таны төр-Та хяна” уриалгыг олон нийтэд дэвшүүлж, мэдээлэл хариуцагчдаас ирүүлсэн, хуулиар ил болгох ёстой мэдээллүүдийг нэгтгэн иргэд, олон нийт, хэвлэл мэдээллийнхэнд нэг цонхоор мэдээлэлд хяналт тавих боломжийг олгож байна. Shilen.gov.mn сайтад анх 9 тусгай зөвшөөрөл олгогч байгууллагын 3450 зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг нээлттэй байршуулж байсан бол өнөөдрийн байдлаар 12.797 тусгай зөвшөөрөл эзэмшигчийн мэдээллийг ил болгосон амжилттай ажиллаж байна.

Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулиар 68 төрлийн мэдээллийг байнга нээлттэй ил тод байлгах аар зохицуулсан ба “Шилэн” ажиллагааны хүрээнд 98 шалгуур үзүүлэлтээр дүгнэж, үнэлгээг долоо хоног тутам олон нийтэд мэдээлж ажилласан. Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны сайдаас Засгийн газрын тусгай санг хариуцсан сайд нар, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн захирлуудад 12 тусгай сангийн мэдээллийг нээлттэй болгох тухай албан бичгийг хүргүүлж хугацаатай үүрэг өгч үр дүнг нийтэд мэдээлсэн. Түүнчлэн 2023 оны 1 дүгээр улиралд тусгай хамгаалалттай газар нутагт газар олгосон талаарх мэдээллийг нээлттэй ил тод болгосон. Тухайлбал, Богдхан уулын дархан цаазат газар (2973га) болон Хөвсгөлийн байгалийн цогцолборт (501га) газар буюу нийт тусгай хамгаалалттай 3474 га газрын болон 2162 иргэн, хуулийн этгээдийн эзэмшил бүхий газрын мэдээлэл ил тод байршуулсан нь тус яамнаас Шил ажиллагааг үр дүнтэй хэрэгжүүлсэн гэж үзэхээр байна.

Мөн Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас шалтгаалаагүй буюу мэдээлэл хариуцагч байгууллагаас шалтгаалсан хангалтгүй хэрэгжилттэй хэд хэдэн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт байна.

Тодруулбал, Монгол Улсын Их хурлын 2023 оны “Хууль батлагдсантай холбогдуулан авах арга хэмжээ тухай” 6 дугаар тогтоол, 2023 оны “Нүүрсний тээвэрлэлт, экспорттой холбоотой асуудлаарх ерөнхий хяналтын сонсголын тайлантай холбогдуулан авах арга хэмжээний тухай” 8 дугаар тогтоол, Засгийн газрын 2023 оны “Шинжлэх ухаан, технологийн салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 120 дугаар тогтоол гэх мэт тогтоол шийдвэрийн биелэлтүүд хангалтгүйгээс гадна, тус яамны чиг үүрэгт хамаарахгүй байх тул хугацаа болоогүй буюу Х.Б-р тэмдэглэн хяналтаас хасуулах саналыг тусгасан болно.

Цахим хөгжил, харилцаа холбооны яаманд хамаарах 220 заалтын биелэлтээс хасуулах санал тусгасан 29 заалт байгаа ба 11 заалт Цахим хөгжил харилцаа холбооны яамны үндсэн чиг үүрэгт хамаарахгүй тул хэрэгжилтээс хасуулах саналтай байгааг онцлон дурдаж байна.

**ДӨРӨВ. ЦААШИД АВЧ ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭ / ЗӨВЛӨМЖ /**

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг гаргахдаа харьяа байгууллагуудын нэмэлт мэдээллийг авч тусгаж хэвших;

2. Тайланг 2000 тэмдэгтээс хэтрүүлэхгүй, зөв бичгийн алдаагүй, тодорхой, ойлгомжтой, эцсийн байдлаар хянагдсан засваргүй тайланг заасан хугацаанд тайлагнаж хэвших;

3. Тайлан нэгтгэлийг хариуцаж буй албан хаагч удирдлагаар баталгаажуулсан эцсийн тайланг өгч хэвших;

4. Бодлогын баримт бичгийн тодорхойлсон шалгуур үзүүлэлтийн дагуу зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг харгалзан бичсэн тайлан өгч хэвших;

5. Засгийн газрын 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-д заасан хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан албан хаагчийн эрх үүрэгтэй танилцан хамтран ажиллахыг цаашид анхаарна уу.

Жич: Яамны газар, хэлтсийн дарга нар дээрх зөвлөмжүүдийг хүлээн авч, нэгжийн албан хаагчиддаа танилцуулах, танилцуулсан хугацаанаас хойш холбогдох арга хэмжээг авч ажиллах үүрэгтэй бөгөөд зөвлөмжийг хэрэгжүүлж байгаа эсэхэд Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газраас төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг хийх болохыг үүгээр мэдэгдэж байна.

Мөн эрчимжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүдийг хэрхэн ахиулах болон тайлагнах талаар Төрийн захиргааны удирдлагын газрын холбогдох албан хаагч, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын албан хаагчдаас зөвлөгөө, дэмжлэг авч ажиллахыг хүсье.